

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-41

1.Улсын Их Хурлын даргын 2024 оны 81 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлт	5-22
2.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан	22-41

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны
07 дугаар сарын 08-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 61.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 27 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Х.Булгантуяа, Ц.Идэрбат, М.Нарантуяа-Нара, Д.Үүрийнтуяа.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг хэлэлцэх асуудлын 2 дугаарт орсон Улсын Их Хурлын даргын 2024 оны 81 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэх асуудлыг 1 дүгээрт хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Л.Энхнасан: Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	5
Бүгд:	15

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Улсын Их Хурлын даргын 2024 оны 81 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг, мөн яамны Залуучуудын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Батдорж, мөн газрын шинжээч Э.Хулан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн ахлах шинжээч Г.Наранбаяр оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, мөн албаны референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 81 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Д.Ганмаа, С.Зулпхар, Л.Энхнасан нарын тавьсан асуултад Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Залуучуудын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Батдорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэбат, О.Саранчулуун, Ж.Баярмаа нар үг хэлэв.

Байнгын хорооны дарга Л.Энхнасан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Л.Энхнасан: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 4

Бүгд: 17

76.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлын даргын 2024 оны 81 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэв.

Уг асуудлыг 17 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер А.Цогбаяр, ахлах аудитор Б.Ариунжаргал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга Г.Адъяа, мөн зөвлөлийн гишүүн Б.Баяраа, Р.Сансармаа, Л.Төр-Од, Э.Энхжаргал, Ажлын албаны аудитор, шинжээч Ц.Оюунбилэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус Мэргэжлийн хорооны дарга Д.Далхжав, Олон нийтийн хяналтын зөвлөлийн дарга Ц.Дашдондог, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, мөн яамны Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга А.Хишигбаяр, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Алтанцэцэг оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, мөн албаны референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Б.Баяраа танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэбат, Ж.Баярмаа, Ц.Мөнхтуяа, Ж.Баясгалан, Л.Энхнасан нарын тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер А.Цогбаяр, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Б.Баяраа, Р.Сансармаа, Э.Энхжаргал, Л.Төр-Од, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, С.Зулпхар, Л.Энхнасан нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэв.

Уг асуудлыг 19 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 44 минут үргэлжилж, 21 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 81.0 хувийн ирцтэйгээр 19 цаг 11 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Л.ЭНХНАСАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
16 цаг 27 минут.

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Энхнасан: Гишүүдийн өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 61,9 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8-д заасны дагуу ирцийг гишүүдийн сонгогдсон тойрог, нэрээр танилцуулъя. Аюушийн Ариунзаяа 10 дугаар тойрог, Цэндийн Баатархүү 4 дүгээр тойрог, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Жудагийн Баярмаа, Жадамбын Баясгалан, 3 дугаар тойрог Буланы Бейсен, 10 дугаар тойрог Хөххүүгийн Болормаа, Даваасамбуугийн Ганмаа, 6 дугаар тойрог Мөнгөнцогийн Ганхүлэг, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Мягмардашийн Сарнай, Сүхбаатарын Эрдэнэбат, 4 дүгээр тойрог Доржсүрэнгийн Үүрийнтуяа чөлөө авсан байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 дүгээрт Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2 дугаарт Улсын Их Хурлын даргын 2024 оны 81 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэх. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Алга байна. Аубакир сайд Эдийн засгийн форум дээр хэлэлцүүлэгт оролцож байгаа гэсэн. Тэр нь дуусаж уу, үгүй байна уу? Хэрвээ үгүй бол 2 дугаар асуудлаа түрүүлж хэлэлцээд, Ганхүлэг гишүүн хаана байна вэ ажлын хэсгийн дарга? Тэгвэл Ганхүлэг гишүүний ахалж байгаа Улсын Их Хурлын даргын 2024 оны 81 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг 1 дүгээр асуудлаар хэлэлцье гэсэн санал гаргаж байна. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Чуулганы хуралдаан болон бусад Байнгын хороо давхардсан, давхардан хуралдаж байгаа. Түүнтэй холбогдолтой гишүүд маань орж, гарч байгаа учраас санал хураалттай асуудлаа урдаа хэлэлцээд, гишүүдийнхээ байгаа дээр санал хураалт юмнуудаа явуулчихъя гэсэн ийм саналтай байна. Тэгэхээр хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулж өгөөч. 2 дахь асуудлыг хамгийн эхэнд хэлэлцэхээр оруулж өгөөч гэдэг санал дэвшүүлье.

Л.Энхнасан: Улсын Их Хурлын даргын 2024 оны 81 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг эхлээд хэлэлцүүлье гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргаж байна. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Өнөөдрийн хэлэлцэх асуудлын 2 дугаар хэлэлцэх асуудал 81 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг эхлээд хэлэлцье гэсэн саналыг дэмжье гэсэн горимоор санал хураалт хийе. Саналыг 66,7 хувиар дэмжлээ. Тэгэхлээр 2 дугаар асуудлаа эхлээд хэлэлцье.

***Нэг.Улсын Их Хурлын даргын 2024 оны 81 дүгээр захирамжаар
байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлт***

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 81 дүгээр захирамжаар байгуулагдсан Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ганхүлэг гишүүнээр ахлуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсож эхэлье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. С.Оюунбилэг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД, ажлын хэсгийг оруулаарай. Г.Батдорж Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Залуучуудын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Наранбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн ахлах шинжээч, Э.Хулан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Залуучуудын соёл, спортын боловсролын бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан шинжээч, С.Бужмаа Хот байгуулалт, барилга хот сууцжуулалтын яам, Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлогын зохицуулалтын газрын Орон сууцжуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн. Эдгээр ажлын хэсгийн гишүүд иржээ.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Мөнгөнцогийн Ганхүлэг танилцуулна. Танилцуулгаа хийнэ үү.

М.Ганхүлэг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 84 дүгээр захирамжаар байгуулагдсан Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг 2024 оны 9 сараас 2025 оны 7 сарын хооронд ажиллалаа. Ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг миний бие ахлан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм, Н.Алтаншагай, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Э.Болормаа, Ш.Бямбасүрэн, Г.Лувсанжамц, М.Сарнай, С.Цэнгүүн, Ө.Шижир нарын бүрэлдэхүүнтэй ажиллалаа.

Ажлын хэсгийн хийгдсэн ажлын товч танилцуулга, ажлын хэсгийн хуралдаан, уулзалтаар ажлын хэсэг 5 удаа хуралдсан. Тамгын газрын төслийн удирдлагын нэгж болон дэмжлэг үзүүлэх баг нийт 20 гаруй удаа хуралдсан. Төрийн болон Олон улсын байгууллага, залуучуудын төлөөлөлтэй 2 удаагийн уулзалт хийсэн. Дорнод аймагт орон нутгийн 70 орчим залуустай уулзалт хийж, санал хүсэлт бүртгэж, шийдвэрлүүлэхээр орон нутгийн удирдлагад уламжилсан. Судалгаанд тулгуурласан 2023-аас 2024 онд хийгдсэн хуулийн дүн шинжилгээ судалгааны тайлантай танилцах ажлуудыг зохион байгуулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгаар Мэргэжлийн социологичдын холбоо Төрийн бус байгууллага 2023 онд хийсэн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын захиалгаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангаас хийсэн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан, Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны цахим санд бүртгэлтэй залуучуудын статистик мэдээлэл, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн хийсэн Гадаадын зарим орны залуучуудын хөгжлийг дэмжих эрхийг хамгаалах үндэсний хууль тогтоомжийн мэдээлэл лавлагааны тайлантай тус тус танилцаж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны бодлого, үйл ажиллагаа, салбарын хэмжээнд тулгамдсан асуудал, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн нөхцөл

байдлын дүн шинжилгээ, үр дагаврын үнэлгээнд Монгол Улсын Хууль зүйн сургуулийн дэргэдэх Герман Европын эрх зүйн төвийн дүгнэлт зөвлөмж, Улсын Их Хурлын Тамгын газрын захиалгаар залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй хууль бодлогын баримт бичгийн олон улс дахь харьцуулсан судалгааг тус тус сонссон.

Хуулийн хэрэгжилтийн эерэг үр дүн төрийн бодлого, залуучуудын оролцоо, эрх, үүргийг хуулиар баталгаажуулсан. Сайн дурын ажлыг эрх зүйн хүрээнд анх удаа тодорхойлсон. Шат шатны Залуучуудын хөгжлийн зөвлөлийг байгуулах суурь тавигдсан. 21 аймаг, 9 дүүрэгт Залуучуудын хөгжлийн төвүүд ажиллаж эхэлсэн. Оюутан залуусын цагийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эрх зүйн орчин бүрдсэн. Залуусын оролцоо, санал дэвшүүлэх боломж өргөжсөн. Төрийн байгууллагын чиг үүрэг, хариуцлага тодорхой болсон. Ажлын хэсгийн хүрээнд тогтоогдсон хүндрэлтэй асуудлууд, хуулийн санхүүгийн суурь заалтууд Залуучуудын хөгжлийг дэмжих сан байгуулах асуудал хүчингүй болсон. Орон нутгийн хүрээнд мэргэшсэн үйлчилгээ үзүүлэх тогтвортой, мэргэшсэн хүний нөөц дутмаг, залуучуудын хөгжлийн төвүүд нь санхүүжилт, дэд бүтэц, арга зүй сул, төрийн байгууллагын уялдаа, чиг үүрэг тодорхойгүй, хуулийн зарим заалт бусад хуультай давхардсан.

Улмаар хуулийн хэрэгжилттэй холбоотой хийгдсэн судалгаа болон салбарын үйл ажиллагааны тайлан, үр дүнг нэгтгэвэл хэрэгжилт хангалттай 34 заалт, зүйл, заалт, хэрэгжилт дундаж 44 зүйл, заалт, хэрэгжилт хангалтгүй 16 зүйл, заалт байна. Дээрх нэр дурдсан судалгаа, үр дагаврын тайлангууд, уулзалт, хэлэлцүүлгийн үр дүнгээс Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн нийт заалтын 50-иас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох шаардлагатай байгаагаас гадна тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай байгаад салбарын мэргэжилтэн, эрдэмтэн судлаачид, ажлын хэсгийн зүгээс санал нэгдсэн.

Тиймээс хуулийг шинэчилсэн найруулах, шинэ нөхцөл байдалд нийцсэн зорилтот бодлого хэрэгжүүлэх шаардлага бүрэн бий болсон гэж үзлээ. Ажлын хэсгийн зүгээс эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлэх, залуучуудын хөгжлийг дэмжихтэй холбоотойгоор доор дурдсан 5 чиглэлээр санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан болно. Санал болгож буй бодлогын шинэчлэл, хуулийн шинэчилсэн найруулга болон Залуучуудын хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг 2025 оны намрын чуулганд өргөн барих, хуулийн хэрэгжилтийг тоон болон чанарын судалгааны арга ашиглан үндэслэлийг боловсруулах үр дүнтэй арга хэмжээг тодорхойлох, Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн хөтөлбөр, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5.2-т заасан Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд боловсрол, залуу малчид, орон нутгийн залуус, хөдөлмөр эрхлэлт, зүрх сэтгэлийн боловсрол гэсэн дараах 5 санаачилгыг Улсын хөгжлийн төлөвлөгөө, улсын төсөвт тус тус тусган хэрэгжүүлэх, 3.1 буюу Боловсролын чиглэлээр Боловсролын зээлийн санг өргөжүүлж, боловсролын хөгжлийн чиглэлээр ажиллуулах.

Залуу малчдыг дэмжих чиглэлээр гэр бүл төлөвлөлтийг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах, эдийн засгийн үр ашигтай бизнес эрхлэхийг дэмжих зорилгоор Залуу малчдыг дэмжих зорилтот хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх. Орон нутгийн залуучуудыг дэмжих зорилгоор бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд залуучууд, залуу гэр бүлийг орон нутагтаа тогтвортой, суурьшилтай ажиллаж, амьдрах нөхцөл боломжоор хангах зорилгоор

жил бүр сумдад 10-аас дээш өрхийг түрээсийн болон хувийн орон сууцад амьдрах, шаардагдах санхүүжилтийн асуудлыг жил бүрийн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр цагийн ажлын шимтгэлийг бууруулж, start-up залуучуудыг дэмжих, Зүрх сэтгэлийн боловсрол олгох чиглэлээр ёс суртахуун, хүмүүжил, төлөвшлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэсэн үндсэн 5 санаачилгыг ажлын хэсгээс дэвшүүлж байгаа юм.

Иймд ажлын хэсгийн зүгээс дээрх 5 чиглэлээр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.6-д заасны дагуу Залуучуудын хөгжил, оролцоог дэмжих талаар хууль тогтоомжийн биелэлтийг эрчимжүүлэх, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжих, эрүүл мэнд, боловсрол, гэр бүлийн асуудлыг шийдвэрлэх болон бүс, орон нутгийнхаа хөгжилд бодитой оролцох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын тодорхой арга хэмжээ авах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх нь зүйтэй гэж үзэн холбогдох тогтоолын төслийг боловсруулсан болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэн, Засгийн газарт чиглэл өгөх тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Энхнасан: Ажлын хэсгийн дарга Ганхүлэг гишүүндээ баярлалаа. Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолыг гишүүдэд тараасан байгаа. Ингээд санал, дүгнэлттэй холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ганмаа гишүүнээр тасаллаа. Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууна уу.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль анх 2012 онд би Нийгмийн ардчилал Монголын залуучуудын холбооны Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байхдаа энэ хуулийн анхны санаачилгуудыг явуулж байсан юм. Улс орон даяар томоохон хэмжээний судалгаа хийгээд, Улаанбаатар хотын ойролцоо байгаа шоронгуудаар бид явж байсан залуучуудтай холбоотой асуудлуудаар. Хар тамхины хэрэглээ болон донтолттой холбоотой, хүчирхийлэлтэй холбоотой олон асуудлууд хөндөгдөж байсан юм.

Тухайн үед Номтойбаяр, Содбилэг гэдэг энэ 2 залуу энэ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг Улсын Их Хуралд Улсын Их Хурлын гишүүн байсан учраас санаачилж оруулж, 2015 онд билүү батлуулсан санагдаж байна, 17 онд ч билүү, 15 он шиг санагдаж байна. Бид энэ залуучуудын хөгжлийг яг яаж дэмжих вэ гэдгээ маш тодорхой л болгомоор байгаа. Ажлын байртай холбоотой асуудлууд байна. Ялангуяа нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой асуудал дээр бид энэ залуучуудын хөгжлийг бүүр үнэхээр боомилж байгаа юм шиг, дарамт болж байгаа юм шиг энэ зүйлээс ангижрах хэрэгтэй. Яг бодитоор нь оруулж ирмээр байна. Нийгмийн даатгал энэ оюутан залуучуудын хувьд хэдий хэмжээний шимтгэл төлдөг байх зарчим руугаа бид орох юм бэ? Хэдээс хэдэн насанд ангилах юм бэ? Бид яах вэ Нийгмийн даатгалын ерөнхий газар /НДЕГ/-тай уулзсан л даа. Тэгээд манай НДЕГ юу гэж хэлдэг вэ гэхээр манай нийгмийн даатгалын тогтолцоо бол эв санааны нэгдэл дээр тулгуурласан тогтолцоо юм гэж хариулдаг байхгүй юу. Энэ 1990 оноос ангижрах болоогүй юм уу? Энэ НДЕГ-ын тодорхой албан тушаалтнууд.

Энэ оюутан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг бид дэмжихгүйгээр энэ ажлын байр бий болохгүй. Ажлын байран дээр өнөөдөр оюутан залуучуудыг жишээлбэл яг энэ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиараа ч юм уу, тодорхой хэмжээнд ажлын байр бий болгож байгаа, залуучуудыг ажлын байраар хангаж байгаа аж ахуйн нэгжүүд дээр энэ нийгмийн даатгалын урамшууллын олгодог систем рүү эсвэл орох ёстой юм уу? Тэгээд энэ эрүүл мэндийн асуудал бол яг ний нуугүй хэлэхэд та хэд өөрсдөө үзээрэй. Манай Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам маань энэ дээр судалгаа шинжилгээ хийсэн юм байна уу, үгүй юү би сайн мэдэхгүй байна. Эрүүл мэндийн яам чухам ямар судалгаа шинжилгээ хийж явдаг юм бэ? Нийт хүн амынх нь 68,7 хувь нь 35 хүртэлх насны залуучууд гээд байдаг. Гэтэл төрөлт буураад байдаг. Залуучууд чинь яг ний нуугүй хэлэхэд амьдрах гэж ядарч байна шүү. Ахмадууд яах вэ дээ тодорхой хэмжээний халамжаа аваад л, үр хүүхдүүд нь тэжээгээд л явж байна. Хүүхэд гаргана цэцэрлэгт өгөх гэж бөөн проблем, сургуульд өгөх гэж бөөн проблем, сургуулиуд нь төлбөртэй болчихсон, ингээд л залуучуудын амьдрал бол яг ний нуугүй хэлэхэд жоохон хэцүү байгаа шүү. Тэгээд хөдөө орон нутаг гээд яривал бүр хэцүү. Тэнд морь мал уяж байгаа тулдаа л зарим залуучууд нь тэсэж байна шүү дээ яг ний нуугүй хэлэхэд. Тэгээд энэ дээр яг нарийвчилж орсон заалт.../минут дуусав/

Л.Энхнасан: Асуулт биш, санал уу? Асуулт. Ганхүлэг гишүүн хариулна.

М.Ганхүлэг: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Тийм 2012 оноос хойш нийгмийн, олон нийтийн байгууллагууд нэлээн идэвхтэй явж байж 2017 онд энэ хууль батлагдсан байгаа. Энэ хуулийн хэрэгжилт дээр төрийн бус байгууллагууд, олон улсын судлаачид саналуудаа хэлээд, бүгдтэй нь ажлын хэсэг дээр танилцсан. Суурь асуудлыг үндсэндээ хангуулах чиглэлээр цаашдаа нэлээн сууриар нь асуудлыг авч хэрэгжүүлэх хэрэгтэй гэдэгтэй санал нэг байгаа. Энэ утгаараа тогтоолын төслийн хамгийн эхэнд үндсэндээ ажлын хэсэг тодорхой гишүүд гэхээсээ илүүтэй салбарын яам энэ хуулийн төслийн шинэчилсэн найруулга дээр төслөө үндсэндээ бэлтгээд ингээд ажиллаж байгаа. Энийг ирэх намрын чуулганаар маш өргөн хүрээнд үндэсний хэмжээнд хэлэлцүүлж, олон талын оролцоог хангаж, нэлээн ул суурьтайгаар үндсэн асуудлуудаа шийдье гэсэн ийм байр суурьтай байгаа.

Ажлын хэсгийн хүрээнд үндсэндээ яг яригдаж байгаа залуучуудын эрүүл мэндийн асуудал, мөн дээрээс нь донтолттой холбогдолтой асуудал, хөдөлмөр эрхлэлттэй холбогдолтой асуудал гээд олон асуудлаар судалгаанууд, мөн дээрээс нь хөгжлийн төлөвлөгөөг салбарын яам дээр хийгдсэн зүйлүүдтэй бид бүхэн танилцсан. Монгол Улсын Засгийн газар 2025 оныг, 2026 оныг Залуучуудын хөгжлийн дэмжих жил болгон зарлана гэдэг энэ тухай асуудлууд ярьж, улмаар үндсэндээ боловсролын асуудал руу эхний удаад хандуулъя гэдэг ийм шийдвэрүүдийг гаргасан. Тэгэхээр цаашдаа улс үндэстний хэмжээнд дийлэнхийг бүрдүүлж байгаа энэ залуучуудын асуудлыг суурь асуудлаар нь шийдэх энэ ажлууд бол энэ ажлын хэсгийн дүгнэлтээр хязгаарлагдахгүйгээр үргэлжлээд явна гэсэн ийм байр суурьтай байгаа.

Өнөөдөр үндсэндээ 2026 оныг бид бүхэн алдаж болохгүй. 26 оны ЗГ-ын хөтөлбөр, мөн улсын төсөв дээр тодорхой чиглэлүүдийг дурдаж байгаа нь энэ нийгмийн эрүүл мэндтэй холбогдолтой, мөн залуучуудын, өсвөр үеийнхний сэтгэл зүйтэй холбогдолтой асуудлыг бид бүхэн 5 дахь заалт болгож оруулж ирж байгаа. Сүүлийн үед нийгэмд гарч байгаа олон асуудлууд бид бүхэн энэхүү асуудал дээр

гол анхаарлаа хандуулж чадахгүй байгаатай холбогдолтой. Тэгэхээр энэ эрүүл мэндтэй холбогдолтой асуудлыг тусгахыг хичээсэн. 2-т нь энэ хөдөлмөр эрхлэлттэй холбогдолтой асуудлыг бид бүхэн 2 чиглэлээр хөндөж байгаа. Хамгийн эхнийх нь цагийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих энэ чиглэлийн хуулийн зохицуулалт 2017 онд батлагдсан хуулиараа олгогдсон байгаа юм. Гэхдээ энэний хэрэгжилтийг илүү сайжруулах, хувь хэмжээний хувьд жоохон ялгавартай байх энэ чиглэлийн асуудлуудыг хөндсөн. Цаашлаад одоогоор Засгийн газраас гарсан журмаар үндсэндээ цагийн хөдөлмөр эрхлэлтийг хэрхэн зохицуулах вэ гэдгийг шийдэж байгаа. Тэгэхээр энийг илүү нарийвчлах гэдэг дээр ажлын хэсэгт үргэлжлүүлээд ажиллаад ингээд явна гэдгээ энэ тогтоолын төсөл дээр тусгасан байгаа.

Мөн дээрээс нь нийгмийн даатгалын шимтгэлийн асуудал байгаа. 35 хүртэлх насны залуучуудыг үндсэндээ бид бүхэн авч үзэж байгаа. Эдгээр залуучууд start-up компани байгуулаад, өөрсдөө хөдөлмөр эрхлээд явахад тодорхой энэ татварын дэмжлэгүүдийг үзүүлэх чиглэлээр манай ажлын хэсгийн гишүүд тодорхой байр сууриа илэрхийлсэн. Ялангуяа.../минут дуусав/

Л.Энхнасан: Гүйцээж хариулъя.

М.Ганхүлэг: Ялангуяа насны хувьд 18-аас 25, 26-аас 35 нас энэ тэр гээд дотор нь тодорхой ангилаад, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 5-аас 7 хувь энэ тэр байхаар тодорхой ийм саналуудыг ажлын хэсэг дээр гаргасан байгаа. Энэ чиглэлээрээ бусад яамнуудтайгаа үргэлжлээд тогтоолын төслийн дагуу ажиллаад явна гэсэн ийм агуулгатай байгаа. Тэгэхээр энэ ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгийн иргэдийг дэмжих энэ чиглэлийн агуулгуудыг тусгахыг хичээсэн.

3 дахь нь энэ залуу малчдын асуудлыг хөндөж байна. Яалт ч үгүй орон нутгийн үндсэндээ малчдын хувьд гэр бүл төлөвлөлтийн хувьд, нийгмийн хамгааллын хувьд олон асуудлууд хөндөгдөж байгаа. Тийм учраас шинэчилсэн хуулийг хүлээгээд байдаг юм уу, тодорхой хөтөлбөрийг хүлээлгүйгээр 2026 онд залуу малчдыг дэмжих үндэсний хөтөлбөрийг зохион байгуулъя. Энэ хүрээндээ энэ залуу малчдын тулгамдаж байгаа асуудлуудыг авч хэрэгжүүлбэ гэдгийг салбарын яамтай бид.../минут дуусав/

Л.Энхнасан: Тодруулга хийнэ үү Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ороод явж байгаа бол сайн байна. 2008 онд Бээжингийн олимп яагаад зохион байгуулах болсон бэ гээд асуусан чинь БНХАУ-ын залуучуудын эвлэлээс залуучуудыгаа ажлын байраар хангаж, эрмэлзэл, идэвх, зорилготой байлгахын тулд ногоон Бээжин хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд бид Бээжингийн олимпыг зохион байгуулсан юм гэж хариулж байсан. Эрдэнэт хот байгуулагдахад уурхайчдад зориулаад Эрдэнэт уулсын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахад хань ижилд нь зориулаад эмэгтэйчүүд ирэх юм байна гээд Эрдэнэт хивсний үйлдвэрийг байгуулж байсан юм. Яг өнөөдөр нөхцөл байдал дээр залуу малчид гээд бид яриад байгаа боловч хөдөө орон нутагт мал дээр гарч байгаа залуучуудын эхнэрийг, жишээлбэл гэргийг нь, ханийг нь гэсэн үг төрийн албанд оруулна гэж хэлээд Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын үед том бодлого, хөтөлбөр хэрэгжсэн. Тэр нь жишээлбэл Булган аймаг дээр очоод орж чадаагүй шүү дээ. Тэр залуучууд бараг ихэнх нь буцаж ирсэн шүү дээ.../минут дуусав/

Л.Энхнасан: Ажлын хэсгээс яамнаас хариулах уу? Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Бид яах вэ залуучуудын асуудал хариуцсан агентлагтай болоод тодорхой ажлууд өмнөх хуулиар бол хэрэгжээд эхэлсэн байгаа. Харьцангуй тооцоо судалгаа хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслүүд дээр тодорхой асуудлууд тусгагдсан байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ удаад бүр онцгойлон илүү бодитой байж болох үүднээс энэ тогтоолын төслийн 3 дахь агуулга дээр энэ залуу малчдыг дэмжих чиглэлийн агуулгыг үндсэндээ оруулж ирсэн байгаа юм. Тэгэхээр энэ чиглэлийн ажлыг яг илүү бодитой болгох чиглэлээр үндсэндээ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам маань тодорхой төслийг олон нийтэд хэлэлцүүлж, ингээд 2026 онд хэрэгжүүлбэ гэдэг ийм санаа байгаа. Тэгэхээр энэ хүрээнд саяын гишүүний хэлж байгаа асуудлыг илүү нарийвчилж тусгаад, нарийвчилсан төлөвлөгөө болгоод ингээд явъя гэсэн ийм бодолтой байна. Харьцангуй энэ агентлаг маань 2, 3 яам руу дамжиж, бүтцийн хувьд яаж явах нь тодорхойгүй байсан байдал асуудалд сөргөөр нөлөөлсөн гэдгийг хэлбэ.

Л.Энхнасан: Тодруулга Бат-Эрдэнэ гишүүн, ахиад 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Энэ удаа Соёл, спорт, залуучуудын дэд хороотой болж байгаа Байнгын хорооны дэргэд. Энэ дэд хороог та хэд маань их сайн ашиглах хэрэгтэй. Эрх зүйн хүрээнд. Энэ бол залуучуудын хөгжлийг дэмжих тал дээр гарч байгаа маш том ахиц. Улсын Их Хурлын дарга Амарбаясгалангийн санаачилгаар явж байгаа томоохон ажил шүү гэдгийг 1 дүгээрт хэлэхийг хүсэж байна. 2 дугаарт Засгийн газрын тогтоол дээр энэ Засгийн газар Ерөнхий сайд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нартай гэрээ байгуулдаг. Энэ дээр бүүр үүрэгжүүлж өгдөг баймаар байна, бүүр яг тусгайчилж, яг залуучуудын чиглэл дээр нь. Тэгэхгүй бол ерөнхийлсөн томъёолол ороод явахаар эргээд гэрээ дүгнэх процесс дээр ерөнхийлсөн хэлбэр дээр явдаг. Тэгээд би Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байсан хүний хувьд иргэдийн Хурлын дарга, аймаг дүүрэг, нийслэлийн Засаг дарга нартай хийж байгаа гэрээн дээр албан ёсоор энэ тодорхой чиглэлүүдийг оруулж өгөөсэй гэж хүсэж байгаа юм. Энэ тогтоолын төсөл дээр нэмж оруулмаар байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Ажлын хэсэг саяын саналыг бичээд аваарай. Ганмаа гишүүн асуултаа асууна.

Д.Ганмаа: Энэ залуучуудын хөгжлийг дэмжих тухай ийм ажлын хэсэг байгуулагдаад, бодвол энэ их хүлээлт өндөртэй залуучуудын дунд манай Монгол хүмүүс чинь ихэвчлэн залуучууд амьдардаг учраас. Тэгээд гол асуудлуудыг нь тусгасан уу, үгүй юү гэдэг надад асуулт байна л даа. Монгол юу гэдэг юм залуучуудын хувьд аваад үзэхээр жишээлбэл мэдээ, мэдээлэл, дата нь хэр зэрэг байдаг юм доо. Би зүгээр бодохдоо залуучуудын харьцангуй гайгүй гэр бүл гэх юм уу даа, харьцангуй ээж, аав нь боломжийн бол хүүхдэдээ нэг байр байшин авч өгөөд, тэгээд боломжгүй залуучууд нь нэг залуу гэр бүл зохиосон бол моргейждээ насаараа, моргейж гэж ч юу байх вэ Монголоор ипотека гэдэг. Ипотекийнхээ зээлдээ баахан мөнгө төлнө, тэгээд л нэг ойр зуур, ойр зуур ч юу байх вэ хэрэглээний машин гээд л баахан зээл тэгээд л зээл төлөлтийн төлөө амьдарч байгаа юм шиг бараг залуучууд. Тэгэхээр нөгөө ирээдүйдээ итгэх итгэл, залуу хүний нөгөө бадрангуй улс орондоо хөгжүүлэх, тэрэнд нь ажиллах юу гэдэг юм тийм идэвх сонирхол их багатай.

Тэр нь миний залуу үед ч гэсэн адилхан байсан даа. Тэгээд тэрнээсээ нөхцөл байдал хэр зэрэг дээрдэж чадаж байгаа юм бол? Бид гайгүй сурдаг нь гадагшаа гарч сурч scholarship авч нэг амьдралаа залгуулъя гэдэг тийм бодолтой байдаг

байсан. Тэгээд ингээд 20 хэдэн жилийн дараа ч гэсэн нөхцөл байдал нэг их дээрдэхгүй. Бид хэрэгцээ, хэрэглээний хувьд их өндөр байх шиг байна харьцангуй их сайн юутай. Тэгэхлээр эдгээр хүмүүсийн тийм мэдээлэл байдаг уу? Хэдэн хүн нь биеэ даагаад яг цалингаараа амьдрах боломжтой байдаг юм залуучуудын, хэдэн хувь нь үнэхээр амьжиргаандаа хүрдэггүй юм, хэдэн хувь нь ямар зээлтэй байдаг юм ч гэдэг юм уу нэг тийм мэдээ, мэдээлэл байдаг уу 1 дүгээрт?

2 дугаарт сая хэн Бат-Эрдэнэ гишүүний ярьж байгаатай би тэр эрүүл мэнд, боловсрол, мөн тэгээд ийм давхардсан хууль, дүрэм журам байдаг уу залуучуудын хувьд юу гэдэг юм давхцал үүссэн? Хэдий сайн хууль магадгүй батлагдчихсан ч гэсэн энэ нь нөгөө салбар хоорондын асуудал аягүй их байгаа байхгүй юу. Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр олголт, спорт юу байдаг юм, эдгээр их асуудлуудыг яаж журам болох юм, хэн хариуцах юм, санхүүжилт нь яах юм гэх мэтчилэн эдгээр асуудал дээр та хэд яаж юу гэсэн санал бодлоо боловсруулсан бэ гэдгийг юуны түрүүнд асуучихъя?

Л.Энхнасан: Ганхүлэг гишүүн хариулна уу?

М.Ганхүлэг: Би сайн дэлгэрүүлж хариулъя. Үндсэндээ залуучуудын өмнө тулгамдаж байгаа олон асуудлууд байгаа. Тэгэхдээ тэр бүх суурь асуудлыг зөвхөн нэг яам байдаг юм уу, нэг хуулиар шийдвэрлэхэд хүндрэлтэй юм билээ. Тэгэхээр суурь асуудлуудыг гаргаж ирсэн тодорхой энэ хуулийн өөрчлөлтөө дагаад ер нь Монгол Улс энэ залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр ямар стратегитай ажиллах вэ гэдэг ийм үндсэндээ цогц хөтөлбөр төлөвлөгөөг хамт Монгол Улсын Засгийн газар болон Их Хуралд харьяа яамнаас өргөн бариарай гэдэг ийм чиглэлийг тогтоолоороо өгч байгаа.

Одоогийн гаргачихсан байгаа төслүүд дээр үндсэндээ бид бүхэн илүү сайжруулаад цаашдаа ажиллана гэсэн үг. Энэ агуулгаараа үндсэндээ тодорхой ярьж байгаа асуудлуудыг нэлээн ул суурьтай хэдүүлээ ярилцах боломжийг олгоё гэж ажлын хэсгээс харж байгаа юм. Тэгэхгүйгээр яг хагас жилийн хугацаанд ярилцаад тодорхой шийдлүүдийг гаргах нь өрөөсгөл байна гэж үзсэн. Ирэх намрын чуулгантай хамт нийгмийн хэлэлцүүлгүүдийг нэлээн өрнүүлж, тодорхой сэдвүүдийн хүрээнд ярилцаж ингэж явах нь зөв гэсэн ийм бодолтой байгаа.

Ганмаа гишүүний хэлж байгаа орон сууцтай холбогдолтой асуудал дээр мөн л энэ удаагийн тогтоолоор бүх асуудлыг гэхээсээ илүүтэй нэг ч гэсэн асуудлыг нь шийдчих юм сан гэсэн хүсэл эрмэлзэлтэй л орж ирж байгаа юм. Ялангуяа орон нутагт очоод үндсэндээ залуу гэр бүл сая Бат-Эрдэнэ гишүүн хэллээ. Ажиллахад хамгийн нэн шаардлагатай байгаа зүйлүүдийн нэг нь энэ ажлын байр, мөн дээрээс нь аятай таатай амьдрах орчин орон сууцын асуудал байгаа. Тэгэхээр Монгол Улс үндсэндээ ипотекийн зээлтэй холбогдолтой буюу тодорхой хүүгийн хөнгөлөлттэй, урт хугацаатай ийм үндсэндээ зээлийг иргэддээ олгоод нэлээн хэвшсэн. Одоо дараагийн үе шат руугаа бид бүхэн энэ орон сууцын реформыг чиглүүлэх шаардлагатай юм гэдэг рүү гол тогтоолын төсөл агуулга маань байгаа юм. Тэгээд бид бүхэн энэ дээр оруулж ирэхдээ энэ залуучуудыг орон нутагт ажиллаж амьдрах, ялангуяа энэ төрийн хэвшлийн, төрд ажиллаж байгаа энэ залуучууд сургуулиа төгсөөд шууд очиход нь ипотекийн зээлээр шууд байр авах ямар ч боломж байхгүй. Урьдчилгаа байхгүй, дээрээс нь ажилласан жил байхгүй. Энэ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиараа үндсэндээ 15-аас 34 насныхныг хамруулж байгаа юм. Тэгэхээр эдгээр үндсэндээ залуучуудын хувьд тодорхой хуримтлал үүсгэх энэ боломж байхгүй энэ цонх үе дээрээ хамгийн хэцүү ийм цаг үе байгаад байгаа юм.

Тэгэхээр үндсэндээ цаашдаа ипотекийн зээл гэдэгтэй адилхан түрээсийн орон сууц гэдэг энэ хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газар онцгойлон анхаарч үзээч. Тэгээд энийгээ үндсэндээ бид бүхэн бодитоор үндсэндээ харахдаа жил болгон сумдад багадаа 10-аас, 10 ийм түрээсийн орон сууцыг шинээр нээх зарчмаар ингээд жил болгон төлөвлөгөөндөө оруулаад ингээд явъя гэсэн ийм үндсэндээ саналыг оруулж ирж байгаа юм. Тэгэхээр ойролцоогоор 350 гаруй сумдад гэж тооцохоор жил болгон түрээсийн орон сууцыг хамгийн багадаа боломжтой бол үүнээс илүү хэмжээгээр олгоод.../минут дуусав/

Л.Энхнасан: Гүйцээж хариулна уу.

М.Ганхүлэг: Олгоод явъя гэсэн ийм гол агуулгыг оруулж ирж байгаа юм. Үүнийг зөвхөн төсвийн хөрөнгө оруулалт гэхгүйгээр төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, мөн Засгийн газрын энэ орон сууцын бодлого, орон сууцжуулах үндэсний хороо гээд одоо явж байгаа энэ бодлогодоо тусгаад, ингээд сайжруулаад явах боломжуудыг цаашдаа судалъя. Энэ рүү чиглэсэн тогтоолын агуулгыг оруулъя гэсэн ийм байдалтай байгаа. Би залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг түрүүн гол дурдаад хэлчихсэн.

Тогтоолын хамгийн юу гол анхаарах эхний хэсэг дээрээ боловсролын асуудлыг бид бүхэн оруулж ирсэн. Боловсролын асуудлын хүрээнд бид бүхэн 3 асуудлыг чиглэл болгож өгч байгаа. Ер нь Монголчууд Боловсролын зээлийн сангаар үндсэндээ гадагшаа сурах зээл авах энэ байдлууд, заримдаа буцалтгүй тусламж хэлбэрээр явж байгаа. Нийт Боловсролын зээлийн сангийн 70-аас илүү хувь нь эргэн төлөгдөх боломжгүйгээр олгогдож байгаа. Тэгэхээр залуучууд үнэгүй юм авъя гэдэг ийм хүсэл сонирхол төдийлөн байхгүй байна гэдгийг ажлын хэсэг анзаарсан. Харин боломжийг илүү ихээр олгож өгөөч гээд. Тэгээд хамгийн эхэнд үндсэндээ заавал гадагшаа явах биш, гадаадын сургуулийг ер нь Монголд авчрах тухай судлах цаг болчихжээ. Гадаадын эхний 50, 100-д багтаж байгаа энэ сургуулиудтай хамтарч ажиллах, эдгээр сургуулиудын салбарыг Монголд байгуулах чиглэлээр ер нь энэ боловсролын зээлийн санг боловсролын хөгжлийн энэ чиглэлийн ажил руу чиглүүлэх энэ агуулгыг энэ дээр нэлээн өөдрөгөөр оруулж ирсэн.

2 дахь нь гаднаас боловсон хүчнийг авчирч сургая гэдэг. Үүнтэй холбогдолтой тодорхой зорилтыг дэвшүүлээд, энэ үндсэндээ зорилтоо тодорхой жил болгоны хөгжлийн хөтөлбөртөө оруулаад, төсөв, санхүүгээ үндсэндээ тусгаад явдаг энэ байдлыг эхлэх цаг болсон гэдэг.

3 дахь нь Засгийн газар жил болгон эрэлттэй мэргэжил гэж гаргаж байгаа, тэргүүлэх мэргэжил гэж гаргаж байгаа. Гэтэл эрэлттэй болон тэргүүлэх чиглэлээр суралцаж байгаа энэ чиглэл рүү үндсэндээ, ахиад юу яачихъя тэгэх үү?

Л.Энхнасан: Нэмж хариулъя.

М.Ганхүлэг: Энэ чиглэлийн боловсрол эзэмших энэ боломж нь хэдийгээр яах вэ зээлээр сургах ийм боломж нь нээлттэй байгаа боловч тоотой байна. Төсөв хөрөнгийн хувьд хязгаарлагдмал ийм байдлууд байна. Тэгэхээр ер нь цаашдаа ажлын хэсгийн гол санал бол Засгийн газар энэ эрэлттэй мэргэжил гэж гаргаж байгаа бол, тэргүүлэх чиглэл гэдгээ тодорхойлж байгаа бол үүнийгээ бүрэн хангагдтал нь маш хүртээмжтэйгээр эдгээр боловсон хүчнийг бэлдэх энэ хүний

нөөцийн бодлогоо дэмжих чиглэлээр үндсэндээ гол энэ агуулгуудаа оруулж ирэх, ялангуяа эрэлттэй болон тэргүүлэх чиглэлээр бүрэн суралцах боломжийг ер нь бий болгох энэ тал руугаа яваасай гэсэн ийм байдлаар тогтоолын төсөлдөө оруулж ирсэн. Энэ Боловсролын зээлийн сан, мөн эрүүл мэндийн чиглэлийн сангууд, мөн дээрээс нь жижиг, дунд бизнесийг дэмжих сангууд руу тодорхой энэ ажлын байр, эрүүл мэндийн чиглэлийн энэ асуудлуудыг чиглүүлэх ийм агуулгаар үндсэндээ оруулсан байгаа гэдгийг хэлье.

Л.Энхнасан: Тодруулга Ганмаа гишүүн.

Д.Ганмаа: Би нөгөө эхний 2 ерөөсөө хэсэг дээр л асууж байгаа юм. 1 дүгээрт энэ хуулийг өргөн мэдүүлэхдээ хэрэгжилтийн үр дүн, үнэлгээ залуучуудын өнөөгийн нөхцөл байдалд тулгамдаж буй асуудлыг тоон болон чанарын судалгаа гэсэн учраас Монгол Улсад хэдэн залуучууд хөдөлмөр эрхлээд, тэр хөдөлмөр эрхлэлтийнхээ боломжоор юу гэдэг юм ажиллах боломжтой байдаг юм, амьжиргаандаа хүрдэг юм, хэд нь моргейжийн зээлтэй юм, хэд нь ерөөсөө зээл авах боломжгүй байдаг юм гэсэн тийм нэг тоон мэдээлэл байгаа юу, үгүй юү? Хот, хөдөөгийн ялгаа нь тэр нь ямар байдаг юм бэ? Хэрвээ тийм мэдээ, мэдээлэл байдаг бол, харсан бол эхнийх нь болохоор.

2 дахь нь болохоор тэр салбар хоорондын асуудал, боловсрол ярьж байна, эрүүл мэнд ярьж байна, хөдөлмөр эрхлэлт ярьж байна, хөгжил, оролцоо, нийгмийн асуудлыг ярьж байгаа учраас энэ хууль хэрэгжсэний дараа ч гэсэн энэ ер нь салбар хоорондын асуудлуудыг яаж, хэн хариуцаж, хэрэгжилт дээр нь арга хэмжээ авах вэ гэдэг дээр нэг хариулт байвал?

Л.Энхнасан: Ажлын хэсэг хариулах уу? 3 дугаар микрофон.

Г.Батдорж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Батдорж байна. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн үнэлгээг 2023 онд хуучнаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулж, үнэлгээг хийлгэсэн байгаа. Манай Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас сая энэ 25 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сантай хамтраад судалгааг зохион байгуулсан байгаа. Энэ судалгааны материалыг Ганмаа гишүүнд хүргүүлье.

Залуучуудын асуудал маань өөрөө салбар дундын асуудал байдаг учраас бидэнд хүндрэлтэй зүйлүүд байдаг. 2023 онд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор 2016 онд үүсгэн байгуулагдсан Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар маань өөрчлөгдөөд, Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын ерөнхий газар болсон үеэс хойш яг энэ.../минут дуусав/

Л.Энхнасан: Нэмж хариулъя Батдорж дарга.

Г.Батдорж: Залуучуудын асуудал хариуцсан яг агентлаг маань байхгүй болоод өнөөдрийг хүртэл явж байгаа. Тэгээд 2024 онд бид Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаман дээр газрын зохион байгуулалттайгаар ажиллаж байна. Ирээдүйд бид Биеийн тамир, спортын улсын хороог залуучуудын хөгжлийн, Биеийн тамир, спорт, залуучуудын хөгжлийн газар гэсэн ийм залуучуудын асуудал хариуцсан агентлаг болгохоор ажиллаж байгаа. Энэ маань энэ Залуучуудын

хөгжлийг дэмжих тухай хуулиараа шийдэгдээд ирвэл залуучуудын асуудал хариуцсан бүтэц маань тодорхой болоод 21 аймаг, нийслэл, 9 дүүрэгтээ энэ салбар дундын үйл ажиллагааг хариуцаж зохион байгуулах ийм боломж нөхцөл нь бүрдэнэ гэсэн ийм хүлээлттэй байгаа.

Өнгөрсөн хугацаанд нийт ипотекийн зээл олгож эхэлснээс хойш 110 мянган иргэд ипотекийн зээл авсны 44 хувь нь 35 хүртэлх насны залуучууд байгаа. Сүүлийн жилүүдэд энэ нөгөө ипотекийн энэ зээл маань харьцангуй бага гарч байгаа учраас яг энэ залуучууд дээр ипотекийн зээл авахад хүндрэлтэй асуудал байгаа. Цаашдаа бид бүхэн зөвхөн орон сууцын ипотекийн зээл гэхээс гадна амины орон сууцын зээл, ногоон орон сууцын зээл гэдэг энэ зээлийн үйлчилгээг энэ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль бол энэ Барилгын яамтайгаа хамтран зохион байгуулах чиглэлээр тооцоо судалгааг хийгдээд явж байгаа. Монгол Улсад яг өнөөдрийн байдлаар ипотекийн зээл болон ногоон зээл, амины орон сууцын зээлд хамрагдах нэн зайлшгүй шаардлагатай 66 мянган иргэн байна гэсэн тооцоо, судалгаа гарсан байгаа.

Тэгээд хуучин Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар ажиллаж байсан Энх-Амгалан сайд, Батсуурь сайд нарын ахалж байсан Үндэсний орон сууцжуулалтын хорооны дүгнэлт дээр жилд Монгол Улс 17 мянган иргэнийг энэ ипотекийн зээл, амины орон сууцын зээлд хамруулаад явах энэ боломж бололцоог 5 жил хэрэгжүүлбэл улс орны хэмжээнд энэ орон сууцын зээл, ипотекийн зээл, амины орон сууцын зээлд хамрагдсанаар иргэдийн асуудал шийдвэрлэгдэх нь гэдэг тооцоо судалгааг хамгийн сүүлийн байдлаар гаргасан байдаг.

Л.Энхнасан: Баярлалаа. Ажлын хэсгийн даргаас асуух хэдэн асуулт байна. Энэ сая нөгөө судалгааны талаар илүү асуулаа л даа. Ер нь энэ тогтоолд хийе гэсэн 5 үйл ажиллагаа шаардлагатай гэж байна шүү дээ. Санхүүжилтийг ер нь тооцсон юм уу? Улсын төсөвт тусгана гэж тооцсон байна. Энэ дээр ер нь нэг тооцоолол хийсэн, судалгаа хийсэн юм байгаа юу? Ялангуяа одоо жишээлбэл тэр саяын ярьж байгаа орон сууцыг 10-аас 1 сумд 10-аас дээш өрхийг түрээсийн болон хувийн орон сууцад амьдрах боломжийг судалж, холбогдох тооцооллыг ингээд танилцуулна гэсэн байна. Ер нь тэгэхдээ хийсэн тооцоолол байгаа юу? Яагаад 10 гэж байгаа юм бэ? Ер нь хөдөө орон нутагт, тэгээд хот гэж ялгаж тооцсон юм байгаа юм уу? Мөн залуучуудын энэ нийгмийн асуудлууд дээр судалсан судалгаа байна уу? Ялангуяа хөдөө орон нутагт явахад хөдөө орон нутаг ч ярилтгүй, нөгөө цэцэрлэг, сургуулиас гадна яслийн хүртээмж, энэ яслийг яагаад ер нь буцаж сэргээж болдоггүй юм бэ гэсэн саналууд маш их ирж байсан.

Энэ 5 дугаар заалт дээр энэ эрүүл мэндийн асуудал орсон байгаад сайшаалтай байна. Харин энэ сэтгэцийн эрүүл мэндээс гадна, сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих гээд аль алийг нь оруулах нь зүйтэй байх. Ялангуяа залуучуудын дунд амиа хорлолт маш их байгаа. 15-аас 35 насны залуучууд яг ажлаа хийх, гэр бүлтэй болох энэ залуучууд маань сэтгэл гутралд орох, амиа хорлох ийм явдлууд маш их байгаа болохлоор энэ дээр анхаарч ажиллаж байгаад баяртай байна. Ганхүлэг гишүүн асуултад хариулъя.

М.Ганхүлэг: Байнгын хорооны даргад баярлалаа. Үндсэндээ тодорхой тооцоо, судалгаатай холбогдолтой асуудлууд хийгдээд ингээд явж байгаа. Ажлын хэсгийн хүрээнд залуучуудын өмнө тулгамдаж байгаа хамгийн их давхардсан асуудлуудыг ер нь хэрхэн шийдэж болох вэ гэдэг талаас нь л харсан. Ер нь нэлээн энгийнээр энэ асуудлуудыг ер нь тодорхойлоод, нэг ч гэсэн асуудлыг шийдчихье

гэдэг ийм л эрмэлзэлтэй орж ирж байгааг Байнгын хорооны гишүүддээ хэлье. Тэр утгаараа бид бүхэн олон улсын судалгаанууд харлаа, тайлангуудыг үндсэндээ үзлээ. Залуучуудын тухай хуулиа шинэчлэх шаардлага юмнууд нэлээн байна гэдэг нь үндсэндээ бүх судалгаанууд дээр гарч ирсэн. 2025 оны намрын чуулганаараа энэ өргөн хүрээтэй бүх асуудлуудыг үндсэндээ хамруулж чадах энэ хуулийн төсөл дээрээ нэлээн өргөн хүрээтэй асуудлаа хөндөөд явна гэсэн ийм бодолтой байгаа.

Энэ тогтоолын төслөөр залуучуудын өмнө тулгамдсан бүх асуудлыг шийдчихнэ гэхээр тийм боломж байхгүй байгаа. Тийм учраас хамгийн их давтагдаж байгаа, ажлын хэсгийн хүрээнд хэлэлцүүлэг, мөн манай ажлын хэсэгт ажилласан ялангуяа дийлэнх нь залуу гишүүд ажилласан. Залуу гишүүдээс маань дэвшүүлж гаргасан хөндсөн эдгээр энэ саналын давхардлуудыг үндсэндээ бид бүхэн гаргаж ирж байгаад залуучуудын энэ боловсролын асуудал дээр ер нь одоогийн байгаа энэ боловсролын зээлийн сантай холбогдолтой, бусад энэ чиглэлтэй холбогдолтой асуудал дээр энгийн ийм шийдлийг танилцуулаад, ингээд цааш нь ажил болгоод явъя гэдэг ийм логик байгаа.

2 дахь нь энэ орон нутгийн залуучууд, тэр дундаа энэ залуу малчдын асуудлыг хамгийн их давхардаж гарч ирж байгаа учраас энэ чиглэлээр ер нь үндэсний хөтөлбөр боловсруулаад ажиллая гэдэг чиглэлээрээ оруулж ирж байгаа. Энэ орон сууцжуулах хөтөлбөр гэхдээ дийлэнх нь төв суурин газар луугаа хангалттай хүрээд байгаа юм. Ипотекийн зээлд хамрагдаж байгаа энэ нөхцөл байдлууд ч гэсэндээ яах вэ энэ дэд бүтэц болон тодорхой үндсэндээ орон нутгийн нөхцөл байдлаасаа хамаарч байгаа юм. Ямар ч байсан өнгөрсөн жил 2025 онд ЗГ-аас 65 сумд 8-аас 12 айлын орон сууцыг хийхээр болсон байгаа. Энийгээ үндсэндээ үргэлжлүүлээд 2026 оноос сум болгонд 10 гэдэг байдлаар явъя гэдэг ийм агуулгыг үндсэндээ дэвшүүлж байгаа юм. Цаашлаад энэнээс ч илүү ахиу болгоод явах энэ боломж бололцоог хийе. Орон сууцын реформ гэж ярихдаа зөвхөн ипотекийн зээл бид бүхэн яриад байгаа нь өрөөсгөл байна. Энэнд ажлын байр дээр гараад багадаа 5 жил, түүнээс дээш жил болсон залуучууд хамрагдах ийм боломжтой байгаад байна. Тэгэхээр дөнгөж гэр бүл болж байгаа, шинэ залуу гэр бүлд зориулсан яг сум орон нутагт очиж байгаа энэ залуучуудад зориулсан түрээсийн орон сууцын энэ нөхцөлийг илүү сайжруулах, төрийн албан хаагчдыг ингэж татах энэ агуулгыг хийгээд явах нь зөв юм гэсэн ийм агуулгаар энд оруулсан байгаа гэдгийг хэлье.

Л.Энхнасан: Баярлалаа. Нэмээд энэ залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаар асуучихъя. Энэ оюутны цагийн хөдөлмөрийн цалин хөлснөөс төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг түрүүн 5-аас 7 хувь тогтоох гэсэн байсан. Энэ тоо ямар тооцооллоор гарсан юм бэ гэж асууя? Тийм, яах вэ би энэ тогтоолынхоо би төсөл дээр уян хатан тогтоох гээд тавьчихсан байгаа л даа. Тэгэхдээ ер нь яагаад 5-аас 7 гэдэг тооцооллууд хаанаас гарсан бэ? Ганхүлэг гишүүн хариулт.

М.Ганхүлэг: Энэ ажлын хэсгийн дүгнэлт дээр байгаа энэ. Яах вэ энэ олон улсын Солонгосын, хэд хэдэн улсууд дээр бид жишээ авч үзсэн. Манай Батшугар гишүүн энэ чиглэлээр тодорхой судалгааны ажлууд, ялангуяа энэ залуучуудыг дэмжих start-up-уудыг дэмжих чиглэлээр тодорхой хувилбаруудыг гаргасан энэ судалгааг бид бүхэнд танилцуулсан юм. Тэгээд тэр агуулгыг энэ дээр татаж оруулж ирсэн байгаа. Гэхдээ энэ тогтоолын төслийн агуулга нь одоогоороо Их Хуралд танилцуулахаар явж байгаа нөгөө багц хууль дээр үндсэндээ ороод явж байгаа. Тэгэхээр энэ ажлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр явж байгаа тэр

төслийнх нь дагуу яг тодорхой хувь заахгүйгээр тогтоолын төсөл дээрээ ер нь уян хатан болгоё гэдэг ийм агуулга явж байгаа юм. Цагаар хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс яг адилхан тодорхой шимтгэл төлөөд байхаар хүмүүс цагийн хөдөлмөрийг дэмжих чиглэлийн юмыг авах хандлага нь бага байгаад байгаа юм. Тийм учраас энэ цагийн хөдөлмөр эрхлэлт дээр арай илүү давуу байдал олгох, хувь хэмжээ.../минут дуусав/

Л.Энхнасан: Баярлалаа. Зулпхар гишүүн асуулт асууя гэж байна. Энэ гишүүд чуулганд байсан учраас асуулт асууж амжаагүй байна. Тэгээд Зулпхар гишүүн асуултаа асууна.

С.Зулпхар: Би асуулт асуухгүй. Саяын асуудалтай холбогдуулаад тайлбар хийх гэж байгаа юм. Энэ Ганхүлэг гишүүний саяын яриад байгаа оюутнууд ажил хийсэн үед нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхой тэр шимтгэлээс нь чөлөөлөх асуудал угаасаа 2 жилийн өмнөөс судлагдаад, тэгээд саяын санал ер нь гарчихсан байгаа юм. Жишээ нь оюутнууд тэтгэврийн даатгалын шимтгэл төлөх шаардлагагүй. Тэрнээс гадна тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөх шаардлагагүй, ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлөх шаардлагагүй. Ер нь гол нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлээ төлчихвөл болох юм. Ингэсэн нөхцөлд нөгөө оюутнуудад гар дээр нь орлого нь илүү үлдэх юм гэсэн энэ үүднээс энэ санал орсон. Тэгэхлээр энэ бол үндэслэлтэй санал шүү гэдгийг хэлмээр байгаа юм. Зөвхөн оюутнуудын тухайд шүү дээ энэ чинь бол. Оюутан хүүхэд ажил хийж байгаад, цагийн ажил хийж байгаад тэрнээсээ илүү гар дээрээ орлоготой болох энэ нөхцөлийг л хангасан юм байгаа юм.

Л.Энхнасан: Эрдэнэбат гишүүн. Ажлын хэсэг үү, биш үү? Үг хэлэх арай болоогүй байна. Гишүүд асуултаа асууж дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу, нэрсээ өгнө үү? Саранчулуун гишүүнээр тасаллаа, Баярмаа гишүүнийг нэмээд оруулах уу төхөөрөмж нь ажилласангүй. Бат-Эрдэнэ гишүүн асуултаа, үгээ хэлнэ үү.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгээд манайх нэг, нэг шат ахиад л явж л байна л даа чааваас. Нөгөө санхүүгийнх нь боломж нь байгаа болохоор ийм байгаа болохоор нээрээ юу ч хэлэлтэй билээ. Заримдаа ч залуучуудаасаа уучлалт хүсмээр болох юм. Энэ гадаадад суралцаж байгаа залуучуудыг эх орондоо урьж авчрах, ажиллуулах ийм нэг хөтөлбөр хэрэгжүүлмээр байна. Энийг бүр ЗГ-т яг ний нуугүй хэлэхэд үүрэг болгож өгмөөр байна. Бид гадагшаа явуулах эх орондоо дэлхийн хэмжээний боловсрол эзэмшихтэй холбоотой асуудал яриад байдаг. Гадаадад чинь олон залуучууд байгаа шүү дээ. Тэнд төрсөн, өсөж байгаа, эх хэлээрээ ярьж чадахгүй болчихсон маш олон залуучууд гадаадад байна. Энэ залуучууд ур чадвартай залуучууд ч энэ дотор зөндөө байгаа. Тэгээд энэ залуучуудыг Монгол Улсад эх оронд нь авчирч урих тодорхой хөтөлбөрийг бид хэрэгжүүлбэл зүйтэй юм болов уу гэж бодож байгаа.

Яах вэ зүгээр квот гээд ярихаар жоохон утгагүй санагдаж магадгүй. БНСУ-д орон нутагт ажлын байраар залуучуудыг хангах хүрээнд төрийн байгууллагууд дээр квот гаргаж өгдөг байхгүй юу Солонгос улсад шүү. Тэгэхээр бид орон нутагт залуучуудыг ажлын байраар хангах хүрээнд явуулбал миний түрүүний хэлээд байгаа нөхөр нь малчин болж очоод, эхнэр нь төрийн байгууллагад шалгалтаа өгсөн тохиолдолд ажиллаж болно гээд явуулсан чинь эхнэрийг нь ажилд Булган аймаг тухайн үед аваагүй байгаа байхгүй юу. Тэгээд эхнэр нь ажилгүй, тэгээд хоёулаа сүүлдээ жил гаруй ажиллаж байгаад больё, больё буцаад хот явъя гээд ингээд хот руу буцаад ирчихсэн байгаа юм. Тэгэхээр яах вэ зүгээр Солонгос улс орон нутагт

ажлын байраар хангах, хүн амын бөөгнөрлийг орон нутаг руу тэлэх гэдэг ч юм уу, бөөгнөрлийг сарниулах хүрээнд явуулж байгаа бодлого гэж харсан. Тэгэхээр энэ орон нутгийг энэ төрийн байгууллагуудыг залуучуудыг ажиллах ажиллуулах ийм тодорхой хэмжээний квотуудыг гаргах боломж байдаг юм болов уу, үгүй юм болов уу? Тэрийг оруулаад өгчихвөл их зүгээр юм болов уу.

Энд зөндөө зээл байна л даа, авч чадахгүй юм л даа. ЖДҮ-ийн зээл л гэнэ, юуны зээл гэнэ. Тэнд яг ний нуугүй хэлэхэд залуучууд ороод учиргүй өрсөлдөөд аваад байх боломж нь нэг талдаа алга. Яагаад гэхээр барьцаа нь алга. Тийм хэмжээний түүх, туршлага нь алга. Мөнгөн эргэлдүүлсэн хөрөнгө нь нөгөө талдаа алга. Тэгэхээр энэ залуучуудын дунд энэ гарааны бизнес start-up санаачилгуудыг нь дэмжих яагаад тусгай сантай байж болдоггүй юм бэ? Энийг ЗГ-т тодорхой хэмжээнд тогтоол дээр оруулж өгвөл яасан юм. Энэ чинь архидалтын эсрэг гээд л архинаас цугларсан зөндөө мөнгө ороод л байдаг, тамхинаас ороод л байдаг, онцгой албан татвараас ороод л байдаг тэгээд огт хэрэглэгддэггүй юм байна лээ шүү дээ. Тэгвэл тэр мөнгөө эргүүлээд залуучуудын гарааны бизнес хөгжлийг дэмжих, ажлын байраар хангах хүрээнд нь тусгай дэмжих сан байгуулаад, тэр сантайгаа нийлүүлээд явдаг юм уу яадаг юм Тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт орох ёстой юм уу. Энийгээ бас нэг хараасай гэж хүсэж байна.

Тэгээд энэ татварын болон зээлийн хөнгөлөлттэй бодлого бол залуучуудад нэн яаралтай хэрэгтэй байгаа. Өнөөдөр бид яах вэ би ахмадуудад загнуулж байсан юм. Чи дандаа залуучууд, залуучууд л гээд ингээд яваад байх юм гээд. Ахмадууд гэж яагаад явдаггүй юм гээд. Уг нь Ач санах тухай хууль гээд ингээд гарчихсан шүү дээ. Тэгээд бид энэ залуучуудыгаа ахмадууд маань уг нь дэмжээд байвал зүгээр л байгаа юм.

Нөгөө талдаа энэ төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудтай хамтарсан залуучуудын санаачилгыг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрүүдийг татварын бодлогоор суулгаж өгвөл зүгээр юм болов уу. Үнэхээр ийм тэтгэлэгт хөтөлбөрүүдтэй болоод эхэлбэл олон залуучууд урамшуулал, хөтөлбөр, ажлын байраар хангагдах боломж нөгөө талдаа бүрдэнэ. Тэрийг нь яах вэ дээ тэгээд л тэр том аж ахуйн нэгжүүд дээрээ тодорхой хэмжээний жижиг ч болтугай татварын хөнгөлөлт үзүүлээд л явчихна биз. Тэгээд ер нь зүгээр цаашдаа Монгол Улс төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтарсан нэгдсэн стратеги хэлбэрээр энэ залуучуудын хөгжлийг дэмжих хүрээндээ явдаг байгаасай. Энэ рүү та бүхэн маань ороосой гэж хүсэж байгаа юм.

Л.Энхнасан: Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа. Эрдэнэбат гишүүн үгээ хэлнэ үү.

С.Эрдэнэбат: Ганхүлэг гишүүний энэ санаачилж байгаа юман дээр талархаж байгаа, дэмжиж байгаа. Бид залуучуудыг жил энэ тэр гээд л ерөнхийдөө нэг лоозогносон юмыг маш л олон удаа тавьж байсан. Тэгээд яг бодит үр дүн, бодит сууриас нь авхуулаад хийх юман дээрээ жоохон алдсан юмнууд байгаа. Ялангуяа энэ хөдөө орон нутагт ингээд явж байхад тэнд ер нь 20, 30 жилийн дараа малчин хүн үлдэхгүй энэ залуучууд. Үндсэндээ энэ соёлын шуурганд маш хурдан автаж байна. Маш хурдан наашаа сэтгэл нь эргэж байна. Тийм учраас бид энийг тогтоон барих, сөрөн тэсвэрлэх гэдэг энэ зүйл дээр маш системтэй, дэс дараалалтай, бодитой ажлуудыг хийх нь шаардлагатай.

Ний нуугүй хэлэхэд хөдөө орон нутаг, зах хязгаар нутгуудаараа үндсэндээ гэрлэх насны 10 залуу байж байхад тэрний гэрлэх насны ойролцоо насны 3 хүн

байгаа, 3 эмэгтэй байгаа байхгүй юу. Тэгэхээр үндсэндээ зарим статистик тоог аваад үзсэн ч гэсэн сэтгэл санаанаас болоод ялангуяа хөдөө орон нутагт байгаа залуучууд амиа хорлох ийм зүйл бүр огцом нэмэгдсэн юм байна лээ. Бүр 4 дахин энэ тэр гэж байна. Энэ яах аргагүй хүн болсон хойно энэ чинь өсвөр насны залуучууд тэгээд сэтгэл гутрахаараа архиддаг. Тэгээд хүн бол өвөл яваад үзэхээр бараг хүн байхгүй дээ, айлд нэг, нэг эрэгтэй залуу л байж байдаг юм. Хүүхдүүдээ аваад ээжүүд нь аймгийн төв юм уу, сумын төв рүүгээ орчихдог, тэгээд ийм өрөвдөлтэй амьдрал угтаж л байгаа юм даа. Тийм учраас бид энэ тал дээр 1 дүгээрт тэр зах хязгаар нутгаа эзэнтэй байлгах, нөгөө талаараа энэ хурдан морь гээд байгаа зүйл маань тогтоож барьж байгаа нэг том хүчин зүйл байгаад байгаа юм. Тийм учраас энэ боловсролын болон эрүүл мэндийн, ялангуяа хүүхдийг нь тэр суманд байлгах, тэр хөдөө, орон нутгийн багийн зуны цэцэрлэг, сургууль гэдэг юман дээр нь маш сайн байхгүй бол хүн болсон хойно хүүхдээ дагаад л 30 гараад л шууд хот руу бүгд л малаа зараад л, нэг байр аваад л, эсхүл нэг приус аваад л тэгээд л амьдарна гээд наашаа гүйж байгаа. Тийм учраас яг ийм системтэй тодорхой ажлуудыг бид бүхэн хийх ёстой гэдгийг хэлмээр байна.

Түрүүн Бат-Эрдэнэ гишүүн хэллээ. Тэр гадаадад байгаа олон залуучуудыгаа буцааж авчрах энэ тал дээр түрүү жил би Солонгос яваад ирэхэд танай 18 мянган хүн манай Солонгос ингээд харлачихсан байхгүй байгаад байна, буцахад нь тусалъя, know how технологийг нь шийдээд өгье. Та нар тэр жижиг, дунд үйлдвэрлэл буцаад очиход нь тодорхой хэмжээний зээл гээд баталгаа өгөхгүй бол хүмүүс итгэхгүй байна, биднийг бараг хүчээр ингээд нутаг буцаах гээд байна ч гэдэг юм уу ингээд итгэхээ байчихсан. Тэгэхээр ийм юмыг маш тодорхой системтэй. Энэ Япон, Солонгосчууд 50, 60 жилийн өмнө яаж залуучууддаа буцааж татаж байсан юм, тийм ажлуудыг энэ хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд хиймээр байгаа.

Тэгээд дээрээс нь энэ сэтгэл юу энэ тэр гээд харахад юу боловч маш чухал юмнууд байна лээ. Энэ сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, сэтгэл гутрал, ганцаардал гэх мэтчилэн ийм зүйл дээр нь энэ залуучууд дээр ийм ажлуудыг хийх шаардлага нэлээн байгаа юм болов уу гэж би харж байна. Тэгээд нийгмийн даатгалын тэр юун дээр харахад яах вэ нийгмийн даатгалын одоогийн хууль дээр орж ирсэн байна лээ. Уян хатан зохицуулах гээд. Нийгмийн даатгалыг оюутан залуучууд төлөхгүй байж болох, эсхүл хөнгөлөлтэй төлөх энэ тэр гээд. Тэгээд энэ тал дээр яах вэ дараагийн хууль орж ирж байхад тодорхой хэмжээгээр хөнгөлөх. Гэхдээ нэг зүйлийг нөгөө талаас нь бодоход залуу хүн ажил хийж байхдаа өөрийнхөө ирээдүйн тэтгэврийг хуримтлуулж байх ёстой. Үүнийг нь ингээд дарамт болоод байна гээд төлөхгүй байгаад байхаар тэр хүн чинь 10, 20-хон жилийн дараа нэг мэдэхэд л 10 жил өнгөрчихсөн байдаг. Дансанд нь хуримтлагдсан юм байхгүй. Тэгээд үндсэндээ ирээдүйн нөгөө нэг бага тэтгэвэртэй, өнөөдрийн нөгөө тэтгэврийн зээлээрээ амьдардаг хүмүүс л дараагийн ээлжид хувирах учраас тэр залуучуудыг харин тэр нийгмийн даатгалыг нь өөр тэр инкубатор сангуудаас дэмжих гэдэг байдлаар нь оруулж өгөх нь хамгийн зөв юм байна лээ шүү гэдгийг би онцлоод хэлье. Тэгэхгүй бол одоогийн залуучууд маань нийгмийн даатгал өнөөдөр төлсөн, төлөөгүй яах вэ гэж. Осолд ордог, нөхөн төлбөр байхгүй, ажилгүй болдог, ажилгүйдлийн даатгал байхгүй. Тэгээд ийм юм руу орох гээд байдаг.../минут дуусав/

Л.Энхнасан: Баярлалаа. Саранчулуун гишүүн үгээ хэлнэ үү.

О.Саранчулуун: Энэ орон нутагт байгаа гэлтгүй ер нь энэ шилжилт хөдөлгөөн ингээд гадагшаа, дотогшоо яваад байгаа шүү дээ. Тэгэхээр би ерөөсөө ийм судалгаа бол ерөнхийдөө харж байгаагүй. Хот, хөдөө болон сумд амьдарч

байхад дэмжих хүчин зүйл юу байдаг вэ? Нийгэм, эдийн засгийн ямар хүчин зүйл дэмждэг юм, ямар хүчин зүйл дэмжихгүй хүчин зүйл болоод байдаг юм бэ? Тэгэхээр ер нь ингээд ЗГ-аас хийж байгаа ажлууд бол тэр дэмжих хүчин зүйлийг нь сайжруулахтай холбоотой ийм, ийм үзүүлэлт байна. Жишээлбэл уг нь жишээлбэл ахмадууд дээр ингэж байгаа байхгүй юу эрүүл мэндийн үйлчилгээ буюу тэр үйлчилгээг нэгээр нэмэгдүүлэхэд ахмадын эрүүл мэнд тэгж өснө ч гэдэг юм уу ийм нэг статистик судалгаатай ийм тооцоолол байх хэрэгтэй байх гэж бодоод байгаа. Түүн шиг залуучуудыг орон нутагт нь амьдруулахад энэ дээр байгаа жагсаалтуудыг мэдээж хэрэг судалгаанд суурилж л гаргасан байх гэж би найдаж байна. Тэгэхээр ийм судалгаа дээр суурилагд хүмүүс баруун бүс, зүүн бүс болон бүс болгонд харилцан адилгүй байгаа байх л даа. Цаг уурын байдлаас хамаараад нөгөө эрхлэх хөдөө аж ахуйн бизнесээсээ хамаараад ингээд аль газар хүмүүс очих тийм боломжтой байна гэдгийг судалсан тийм судалгаа дээр үндэслэж, байшин барилга барих юм уу, тийм судалгаан дээр үндэслэж сургууль байгуулах юм уу ч гэдэг юм уу ийм зүйлүүдийг гаргах ёстой гэж бодоод байна.

Жишээлбэл газар тариалан эрхлэх боломжтой, интернэт сайн хөгжсөн газар бол залуучууд нүүж очих боломжтой байна байх. Гэтэл зүгээр л сумдаа амьдрах хэрэгтэй, хөдөө амьдрах ёстой гээд байхаар яг үнэндээ яваад очъё гэхээр нөгөө газарт нь интернэт байхгүй, ус байхгүй бол нөгөө ногоогоо тариад амьдаръя гэдэг хүсэл нь яах билээ. Тэгвэл яг мал маллаад байя гэхээр аль бүсэд нь ямар юм хэрэгтэй гэдэг дээр яг ийм судалгаанд суурилсан тооцоолол хийж байж бүтээн байгуулалт, дэд бүтэц рүү анхаарах хэрэгтэй гэж бодоод байгаа. Өмнө нь ч гэсэн бид Боловсролын байнгын хороон дээр ярьж байсан шүү дээ. Сургууль бариад байдаг, гэтэл хүн амын өсөлтийн прогнозоороо зарим газар сургууль дүүрэхгүй. Гэтэл зарим газар дүүрээд байгаа. Тэгэхээр энэ залуучуудын шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх хүчин зүйлийн судалгааг ер нь хийсэн юм уу, үгүй юу. Тэн дээр анхаарч, тооцоолол гаргаж байж, тоосго барих, нэг тоосгыг босгож байшин барих, дэд бүтэц ярих юмыг шийдэхгүй бол залуучуудыг дэмжиж байна гээд очоод нэг юм хийхэд өөр хүчин зүйл байсан байвал хүн чинь дахиад л нүүж очихгүй байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр өнөөдөр залуучуудад хөдөө орон нутагт амьдрахад болон ер нь эх орондоо эргэж ирэхэд ямар хүчин зүйл дэмжих вэ, дэмжлэг үзүүлэх вэ, юу нөлөөтэй вэ гэдгийг судалсан байх ёстой гэж би бодоод байгаа юм. Тэгэхээр энэ Байнгын хорооны тогтоол дээр ийм судалгааг оруулж ирж байж, энэ судалгаанд суурилсан хүн амын шилжилт хөдөлгөөн, түүнд нөлөөлөх хүчин зүйл дээр үндэслэж байж эдгээрийг хийнэ гэдэг ийм агуулгыг оруулах ийм саналтай байна. Яг энэ тогтоолын энэ 2 дахь хэсэг дээр магадгүй тэгж оруулбал илүү ул суурьтай байх болов уу гэж бодож байна.

Л.Энхнасан: Зүйтэй, ер нь судалгаа дээр үндэслэнэ л дээ. Тэгэхлээр энэ заалтыг нэмж оруулъя. Баярмаа гишүүн үгээ хэлнэ үү.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Тэгээд энэ чухал тогтоолын төсөл байна л даа. Яагаад гэвэл мэдээж Монгол Улсын чинь хүн ам 3 сая 500-аас 30 хүртэлх насны хүн ам нь 1 сая 833 юм байна. Өөрөөр хэлбэл 52 хувь нь. Тэгэнгүүт сая манай Саранчулуун гишүүн их зөв асуудал хөндөж байна. Судалгаанд суурилах ёстой гээд. Тэгээд та бүхэн санаж байгаа бол хувь хүний орлогын албан татварыг 1 хувь болгох энэ санаачилга дээр дэмжиж гарын үсэг зурсан 100 мянган хүний 50 хувь нь 30 хүртэлх насных. Тэр юу чинь аягүй гоё гаргаад ирдэг юм байна шүү дээ, диаграммаар маш сайн гаргадаг юм байна. 85 хувь нь 40 хүртэлх насных байгаа

байхгүй юу. Тэгээд энийг бол би судалгаа гэж бодож байгаа. Энэ чинь яах вэ нөгөө санал өгч байгаа нь өөрөө бараг л судалгаа болчхож байна шүү дээ. Тэгэхээр энэтэй би холбож юуг хэлэх гээд байна вэ гэвэл 40 хүртэлх насны залуучуудын 85 хувь нь татварын дарамтад байна гэсэн үг, маш тодорхой харагдаж байна.

Тэгээд ер нь залуучуудтай ярьж байхад яг энэ асуудлыг маш их ярьж байна. Тэгэхээр мэдээж бид тодорхой залуучууд дундаа сегментэд хандах нь чухал, малчин залуучууд. Мэдээж Монгол Улсын нүүдлийн соёлыг тээгч, цаашид уламжилж авч явах ёстой чухал субъект мөн үү гэвэл мөн. Гэхдээ ерөнхий ингэж сегментлэхгүйгээр энэ бүх залуучуудад тулгамдаж байгаа асуудлыг маш сайн судалж, тэр лүү чиглэсэн асуудлыг уг нь энэ юундаа тусгаж өгвөл ямар байсан юм бол гэж сая бодогдлоо л доо. Тэгэнгүүт залуучуудтай санал солилцоход бол яг ажил хөдөлмөр эрхэлдэг, цалин авдаг, нийгмийн даатгалын шимтгэл төлдөг стандартаараа явж байгаа тэр залуучуудад зориулсан бодлого их чухал санагдаж байна л даа. Тэгэхээр заавал ч үгүй тусгайлан авч үзэхээс илүү бүгдэд нь хамгийн их тулгамдаж байгаа асуудал юу вэ гэдгийг маш нягтлан судалж, энэ тогтоолын төсөлдөө тусгасан бол, тусгавал сайн юм шиг санагдаж байна.

Дээрээс нь залуучууд яг нэг л зүйл хэлж байлаа шүү дээ. Яагаад 65 хүртэлх насны иргэдээс судалгаа авахад 65 хувь нь гэж байгаа шүү дээ, би андуураагүй бол, нөгөө Булгантуяа гишүүний сайд байх үедээ ярьсан яриа байдаг байх, ярьсан яриа юу байх вэ судалгаа байдаг. Боломж гарвал гадаадад явмаар байна гээд. Тэгэхээр чинь 65 хүртэлх насны иргэд нь бүүр ингэж хэлж байгаа юм чинь тэр 30, 40 хүртэлх насны залуучууд явах гэж тэмүүлэх нь бүүр аргагүй шүү дээ. Ажил хийе татварын дарамт. Тэгээд бас залуучуудад шударга бусын дарамт асар их байна гэж ярьдаг юм байна лээ. Үнэхээр шударга бус байна л гээд байгаа юм. Тэр татвар энэ тэр бол нэг хэрэг. Гэтэл бид мянга ажил хийгээд, бид зүгээр жирийн залуучууд ерөөсөө амжилт бүтээл олохыг мөрөөдөөд ч хэрэггүй болчихсон энэ цаг үе байна. Заавал ч үгүй нэг дээр үеийнхээр бол арын хаалганы шинжтэй дарга, улс төрчидтэй холбоотой залуучуудын бизнес явдаг болсон. Бид мянга махаа идээд ямар ч нэмэргүй болсон, одоо үнэхээрийн Монголд амьдрах боломж байхгүй байна гээд. Тэгээд дахиад гадаад явахын тулд хамаг юмаа бардаг юм байна. Сая миний нэг найз 2 залуу 60, 70 сая төгрөг зарцуулсан байна шүү дээ Канад явах гээд. Бизнесийн виз авч явах гээд бүр аргаа бараад, Монголд бизнес хийж чадахгүй, Канадад очвол боломжтой юм шиг байна гэж бүр ярьж байна шүү дээ.

Гэтэл Монголд боломж асар их байгаа шүү дээ. Нэг Япон хүний хэлсэн үг байдаг шүү дээ. Монголд нэг л болохгүй юм байна гээд, юу гэсэн чинь бүх юм нь болохгүй байна гэсэн байгаа юм. Үгүй ээ тэгээд энэ чинь юу нь болж байгаа юм гэсэн чинь болохгүй байх тусмаа та нарт хийх юм их байна гэсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр өөрөөр хэлбэл Монголд энэ залуучуудад хийх зүйл асар их байгаа боловч энэ төрийн дарамт, энэ алагчил, энэ ялгаварлан гадуурхалт чинь энэ залуучуудыг байж суух аргагүй болгож байна шүү дээ. Брэйн Дрэйн бол юу ч биш. Бүх төрлийн, бүх залуучууд гадагшаа гарахыг л хүсэж мөрөөдөж байна. Тэгэхээр эд нарыг тогтооход.../минут дуусав/

Л.Энхнасан: Баярлалаа. Ажлын хэсгийн дарга, гишүүдээс ирсэн саналуудыг бүгдийг нь авч, энэ тогтоолдоо тусгаж, шинэчлэх нь зүйтэй юм байна. Ингээд гишүүд үгээ хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 84 дүгээр захирамжаар байгуулагдсан Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ганхуяг гишүүнээр ахлуулсан ажлын

хэсгийн, Ганхүлэг гишүүнээр ахлуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцлээ.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Сая гишүүдээс ирсэн саналыг тусгаж, найруулгатай тийм, найруулга оруулаад, ялангуяа энэ судалгаа тооцоо, энэ татварын хөнгөлөлт, start-up бизнес, энэ тусгай сан байгуулах талаар судлах, тэр хөдөлмөр эрхлэлтийг судлах, шударга бус байдлын талаар гээд эдгээр, гадаадад байгаа залуучуудыг татах энэ үндэсний хөтөлбөр боловсруулах талыг судлах гээд Ажлын алба ингээд тогтоолыг найруулаад, тэгээд батлах нь зүйтэй юм гэж үзэж байна. Гишүүд, танилцуулах уу? Тогтоолын, энэ тогтоолоо танилцуулчих уу? Тогтоолын төслийг уншъя.

Нийгмийн бодлогын хорооны тогтоол. Засгийн газарт чиглэл өгөх тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

1 дүгээрт, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, залуучуудын өнөөгийн нөхцөл байдлын үр дүнд үндэслэн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг залуучуудын боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, хөгжил, оролцоо, нийгмийн асуудлыг иж бүрнээр шийдвэрлэх зорилго, зорилтыг тусган, хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг тус тус боловсруулж, 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Занданшатар/-т даалгасугай.

2 дугаарт Монгол Улсын Их Хурлаас баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын хуульд заасан хөгжлийн зорилгод хөтөлбөрийн хүрээнд боловсрол, залуу малчид, орон нутгийн залуус, хөдөлмөр эрхлэлт, хүмүүжил, ёс суртахуун гэсэн 5 үйл ажиллагааг шаардлагатай санхүүжилтийн хамт улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөвт тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Занданшатар/-т даалгасугай.

1 дүгээрт, эх орондоо дэлхий жишигт нийцсэн боловсрол эзэмших нөхцөл бололцоог бүрдүүлэх хүрээнд дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэлээр тухайн жилд тогтоосон эрэмбийн жагсаалтын эхний 50-д багтсан сургуулиас багш, судлаач нарыг урьж ажиллуулах. Тус сургуулийн салбарыг Монгол Улсад нээх боломжийг судлах, залуучуудын дижитал ур чадварыг сайжруулах чиглэлээр тэгш хүртээмжтэй боловсрол олгох бодлогыг хэрэгжүүлэх.

2 дугаарт, залуу малчдыг дэмжих хүрээнд уламжлалт, нүүдлийн мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, дасан зохицох чиглэлээр тэдний хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, залуу малчдын гэр бүлийн төлөвлөлтийг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах, эдийн засгийн үр ашигтай бизнес эрхлэлтийг дэмжих.

3 дугаарт, орон нутгийн залуучуудыг тухайн аймаг, сумдаа тогтвор суурьшилтай ажиллах, амьдрах нөхцөл боломжоор хангах хүрээнд сум бүрд жилд 10-аас дээш өрхийг түрээсийн болон хувийн орон сууцад амьдрах боломжийг судалж, холбогдох тооцооллыг танилцуулах.

4 дүгээрт, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмыг шинэчлэх, оюутны цагийн хөдөлмөр, цалин төлснөөс төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг уян хатан тогтоох, Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн зарцуулалтын тодорхой хувийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж буй залуучуудад зарцуулах.

5 дугаарт, өсвөр үе, залуучуудын хүмүүжил, ёс суртахуун төлөвшүүлэх хүрээнд тэдний сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, бие хүн болж төлөвшихөд чиглэсэн үйл ажиллагааг засаг захиргааны нэгжийн Засаг дарга бүрд тэгш хамралтын зарчим дээр үндэслэн хэрэгжүүлэх.

Гуравдугаарт энэ тогтоолын биелэлтийн явцыг Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтааж танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Занданшатар/-т даалгасугай.

Дөрөвдүгээрт энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо /Энхнасан/-д үүрэг болгосугай гээд. Гишүүдийн саналыг тусгаад, ингээд Байнгын хорооны тогтоолыг баталъя гэсэн нэр томъёогоор санал хураалт хийе. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Болсон уу? Ганхүлэг гишүүн. Санал хураалт явъя. Дэмжье, тогтоолыг дэмжье гэсэн нэр томъёогоор санал хураалт. Баярлалаа. Ажлын хэсэг сайн ажиллалаа. 76,5 хувиар дэмжигдлээ. Болоогүй одоо, тэгье. Ажлын хэсэгт баярлалаа. Ганхүлэг гишүүнд баярлалаа. Анх удаа залуучуудын асуудал манай Байнгын хороогоор орлоо.

17.50 цаг

Хоёр.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан

Нийгмийн даатгалын, санал хураалт байхгүй. Тэгье. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцье. Ажлын хэсгийг оруулаарай. Аубакир сайд Эдийн засгийн форумаасаа гарсан уу, хэн танилцуулах юм бэ? Сайдыг дуудах уу? Түрүүн сайдаас болоод бид 15 цаг 40-д хойшлуулсан шүү дээ. Одоо тэрнээс хойш, Аубакир сайдыг дуудаж байна энэ ордонд байгаа юм чинь. Сайдаа дуудаарай.

Ажлын хэсгийг танилцуулчихъя. Г.Адъяа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Р.Сансармаа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Л.Төр-Од Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Б.Баяраа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Х.Буянжаргал Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Г.Саран Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын зөвлөх, Ц.Оюунбилэг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны аудитор, шинжээч, Б.Батжаргал НДЕГ-ын дарга, Д.Далхжав Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус мэргэжлийн хорооны дарга, Ц.Дашдондог Олон нийтийн хяналтын зөвлөлийн дарга, Э.Одонтуяа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны ахлах аудитор, шинжээч, В.Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, А.Хишигбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга, Ц.Ганцэцэг НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга, Б.Алтанцэцэг НДЕГ-ын Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга. Үндэсний Аудитын газраас

Б.Ариунжаргал Үндэсний аудитын газрын ахлах аудитор, А.Цогтбаяр Үндэсний аудитын газрын аудитын менежер. Эдгээр ажлын хэсэг ирсэн байна.

Сайдыг дуудаарай, сайд маань яаж байна вэ? Аубакир сайд хэлэлцүүлэгт оролцож байгаа учраас яг одоогоор, тэгэхдээ сайдад хэлээрэй. Тийм сайд, зөвлөлийн гишүүнээр танилцуулгаа хийлгэчихье гэсэн санал өгсөн байна. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх танилцуулгыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Баяраа танилцуулна. 1, 2. 5 дугаар микрофон.

Б.Баяраа: Энэ хуралд оролцогч та бүхэндээ энэ өдрийн, энэ оройн мэндийг дэвшүүлье. Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь тайлангийн хугацаанд нийгмийн даатгалын шинэчлэлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлого чиглэл, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, цахимжуулахад чиглэсэн зохицуулалтыг хийж, даатгуулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг авч ажиллалаа. Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тэтгэврийн шинэчлэлийг хийх, даатгуулагчийн нэрийн дансны орлогыг үе шаттай мөнгөжүүлэх, тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилтын хүрээнд тэтгэврийн нөөц сантай болох, 2024 онд нийгмийн даатгалын шимтгэл төлж буй 1,2 сая даатгуулагч миний тэтгэврийн мөнгөн хуримтлалтай болж, нийт 215,3 тэрбум төгрөгийн бодит мөнгөн хуримтлал үүслээ.

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, сангийн орлогыг бүрдүүлэх, зарцуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах, шийдвэр гаргахад шаардлагатай судалгаа, эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн хороо, үйл ажиллагаанд нь хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий орон тооны бус Олон нийтийн хяналтын зөвлөлийг байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлэв. 2024 онд 300 тэрбум төгрөгөөр ЗГ-ын урт хугацааны бондыг 8,5-аас 9,5 хувийн хүүтэйгээр 1-ээс 3 жилийн хугацаатайгаар худалдан авч, нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг 55 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжийг бүрдүүллээ.

Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд нийт 22 эрх зүйн баримт бичгийг шинээр болон шинэчлэн батлуулж, мөрдөн ажиллаж байна. 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 500,6 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр дундаж тэтгэвэр 785,6 мянга, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 650 мянга, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 540 мянган төгрөг болж нэмэгдлээ. Мөн дараалсан 7 жилийн цалин хөлсний дунджаас тэтгэврээ тогтоолгосон нийт 73,1 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг 5 жилийн дундаж цалин хөлснөөс тооцож, тэтгэврийг нь нэмэгдүүлэн тогтоолоо.

0-3 нас, 18 нас хүртэлх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа сайн дураар даатгуулагч 24,4 мянган эх, эцэг болон 51,5 мянган малчны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлд 35,7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс тус тус хариуцан төлж, нийгмийн даатгалд хамруулав. Өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалтад хамрагдсан нийт 2226 тэтгэвэр

авагчийн тэтгэвэр нэмэгдлээ. 2024 онд нийгмийн даатгалын шимтгэлд 5,6 их наяд төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 719,9 мянган хүнд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардалд 5,1 их наяд төгрөг зарцуулсан байна. Нийгмийн даатгалын үйлчилгээг цаг хугацаа, орон зай харгалзахгүйгээр цахим хэлбэрээр хүргэж, нийгмийн даатгалын байгууллагуудын цахим систем нь бусад байгууллагуудын дэд системтэй шууд холбогдож, шаардлагатай тооцооллуудыг автоматаар хийж, иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, харилцагч байгууллагуудад үзүүлж буй нийгмийн даатгалын үйлчилгээний 85 хувь нь цахимжсан байна. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа нь ИМонголиа үндэсний цахим системийн хамгийн эрэлттэй үйлчилгээг тэргүүлж байна.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд 2024 онд нийт 4 удаа хуралдан, 19 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 12 тогтоол батлан гаргаж, нийтээр заавал дагаж мөрдүүлэх 5 тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэв. Капитал, Чингис хаан банкнаас нэхэмжилсэн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор ажлын хэсэг байгуулж, банкны өрийн болон зээлийн барьцаанд байгаа нуугдмал хөрөнгийг олж илрүүлэн нийгмийн даатгалын санд учирсан хохирлыг арилгах, нэхэмжилсэн өр төлбөрийг барагдуулахад хамтран ажиллах хүсэлтийг Улсын ерөнхий прокурорт дахин гаргаж, Авлигатай тэмцэх газарт холбогдох нэмэлт материалыг хүргүүлсэн. 2024 онд Капитал банкнаас 2,4, Чингис хаан банкнаас 5,07 тэрбум төгрөгийн 3 үл хөдлөх хөрөнгийг нийгмийн даатгалын сангийн нэхэмжилсэн өр төлбөрт тооцон авч, 1,5 тэрбум төгрөгийн өр авлагыг барагдуулж, Капитал банкнаас 65,7, Чингис хаан банкнаас 95,2 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

2025 оныг даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил болгон зарлаж, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй, ил тод байлгаж, байгууллагын хөгжил, тогтвортой үйл ажиллагааг хангах, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд, даатгуулагчид, тэтгэвэр авагчид чирэгдэлгүй, шуурхай хүргэх зорилгоор нийгмийн даатгалын салбарын хэмжээнд дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд, нийгмийн даатгалын багц хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нээлттэй, авлигаас ангид байлгахад чиглүүлэх.

Тэтгэврийн хуримтлалаас хуримтлалын тогтолцоонд, тэтгэврийн хуваарилалтаас хуримтлалын тогтолцоонд шилжиж байгаатай холбогдуулан тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, хөрөнгө оруулах, даатгуулагч тус бүрээр хуваарилах ажлыг зохион байгуулах. Иргэд даатгуулагчид хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт сайн дурын үндсэн дээр хамрагдаж, нэмэлт тэтгэвэр авах эрх зүйн орчныг бүрдүүлэх. Мэргэжлийн хороо, олон нийтийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэр гаргахад шаардлагатай судалгаа, эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах, хяналт тавьж ажиллах замаар нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөн нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлагын чадавхыг сайжруулах, нийгмийн даатгалын мэдээллийн системийг хөгжүүлж, нийгмийн даатгалын байгууллагуудын болон нийгмийн даатгалын сангийн санхүүгийн системийг бүрэн цахимжуулах, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагч, ажил олгогчид хүртээмжтэй болгох,

даатгуулагчдын санхүүгийн хуримтлалыг дэмжсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулах. Эдгээр зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлснээр нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдаж, иргэд, даатгуулагчид, ажил олгогчид үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээ улам сайжирна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Баяраа танилцуулж дууслаа. Аубакир сайд сая орж ирж байна. Ингээд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Ингээд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Баярмаа гишүүнээр, Ганмаа гишүүнээр тасаллаа. Мөнхтуяа гишүүний нэрийг оруулна уу. Мөнхтуяа гишүүнээр, Саранчулуун гишүүнээр тасаллаа. Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууна уу.

Б.Бат-Эрдэнэ: Нийгмийн даатгалын сан харамсалтай зүйлүүд их байгаа. Манай улс, манай улсын эдийн засаг улс төрийн эдийн засаг гэдэг шиг нийгмийн даатгалын асуудлууд маань хүн амтайгаа шууд холбогддог учраас улс төрийн зорилгоор энэ асуудлууд яваад байгаа. Энийг та хэд маань надаар хэлүүлэлгүй мэдэж байгаа байх. Тэр тэтгэврийг тэглэсэнтэй холбоотой асуудал, өнөөдөр Монголбанкнаас гаргаж байгаа тэтгэврийн зээлийн хязгаарлалттай холбоотой асуудлууд ч гэсэн ялгаагүй л холбогдож байгаа. Энэ улс төржилтөө давж, төрийн бодлого нь явж ерөөсөө чадахгүй байна л даа.

Тэгээд нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийг мэргэжлийн түвшинд байгаасай гэж хүсэж байгаа. Албан бус эдийн засаг ихтэй гэж хардаг. Ялангуяа энэ хөдөлмөр эрхлэлтийн бүтэц тогтворгүй, түр хугацааны ажил, цалин багатай, ажлын байр давамгайлдаг, шимтгэлийн орлого тогтмол биш байгаатай холбож үздэг нэг талдаа. Бид цалин хөлсний тэгш бус байдал, доогуур орлоготой иргэдийн шимтгэлтэй холбоотой асуудал дээр ер нь цаашдаа яах ёстой юм бэ? Энэ нийгмийн даатгалын шимтгэлтэй улбаатайгаар өндөр гэж яриад байгаа шүү дээ. Гэтэл төр нь бага гэж яриад байгаа юм. Нийгмийн даатгалын уян хатан бодлого байхгүйгээс улбаатай тогтмол ажлын байр, тогтмол орлогожих процесс нь бага, албан бус хөдөлмөр эрхлэлт ихтэй, албан бус хөдөлмөр эрхлэлтээс улбаатай хөдөлмөрийн осол ихтэй, тэтгэвэр тэтгэмж, халамж авдаг хүмүүсийнх нь тоо ихтэй, төрөлттэй ч нөгөө талдаа холбогддог. Бид цаашдаа энэ нийгмийн даатгалын сангаа яаж авч явах нь зөв зүйтэй юм бэ гэдгийг нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс асуумаар байгаа юм?

Аудит хийгддэг, тодорхой хэмжээнд танилцуулсан болоод өнгөрдөг. Дүгнэлт нь тэгэх ёстой, ингэх ёстой гээд өнгөрдөг ийм хэлбэр дээр өнөөдрийг хүртэл явж ирсэн. Тэгэхээр хэдүүлээ энэ нэг Байнгын хороо нэгэнт хуралдаад энэ тайланг сонсож байгаа цаг хугацаатай давхцуулаад нийгмийн даатгалын үндэсний зөвлөл Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, холбогдох байгууллагууд яг зоригтой хуульчилбал хуульчлах шийдвэрүүдийг оруулж ирмээр байгаа юм. Цаашдаа хэн нэгэн Ерөнхийлөгч нь гарч ирээд, хэн нэгэн Ерөнхий сайд нь гарч ирээд, хэн нэгэн Улсын Их Хурлын дарга нь гарч ирээд ахмадуудын тэтгэврийг тэглэсээр л байх юм уу, энийгээ хэдүүлээ эрх зүйн чадамжийн хувьд яах ёстой юм бэ гэдэг дээр би зүгээр асуулт асуух гэсэн юм дүгнэлттэй холбоотой хэсэг дээр?

Л.Энхнасан: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд, яамнаас, зөвлөлийн гишүүд хариулах уу? Сансармаа гишүүн 3 номер. Уучлаарай 4 дүгээр микрофон юм байна.

Р.Сансармаа: Сайн байцгаана уу. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогчийн төлөөлөл Сансармаа. Бат-Эрдэнэ гишүүний ярьж байгаа, санаа зовж байгаа бүр үнэхээр аргагүй. Улс төрөөс үнэхээр хамааралтай их олон шийдвэрүүд гарсан учраас хүндрэлүүд үүсчихсэн явж байгаа. Эндээсээ сая Энх-Амгалан сайд нийгмийн даатгалын байгууллагатай хамтраад тогтолцооны шинжилгээ хийлгээд, ер нь яаж улс төрөөс ангид байх вэ гэдэг тал дээр нэлээн олон хуулиудад нэмэлт, өөрчлөлтийн саналууд оруулчих шиг болно лээ.

Тэгээд ажил олгогчийн зүгээс юу гэж харж байгаа вэ гэвэл бид нэг тийм хууль болон татвар, нийгмийн даатгалын шимтгэл эд нар бол нэг тийм тэгш байх бүгд төлдөг байх энэ байдал дээр нэлээн анхаарах ёстой гэж үзэж байгаа. 23 оны нийгмийн даатгалын байгууллагын тайлангаар 70 мянган ААН-үүдээс 60 гаруй хувьтай нийгмийн даатгалын төлөлттэй, үлдсэн 30 гаруй хувь нь төлдөггүй гэсэн мэдээлэл ирсэн. Нэгэнтээ үйл ажиллагаа эрхэлж л байгаа бол энэ үйл ажиллагаа эрхэлж байгаа бүх байгууллагууд нийгмийн даатгалын шимтгэлийг тэгш төлөөд явбал энэ байдал нэлээн засрах юм гэж бодоод байгаа. Мөн 2024 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа манай нийгмийн даатгалын багц хуульд нийгмийн даатгалын хуримтлалын тогтолцооноос хуваарилалтын тогтолцоо руу шилжих нэг ийм зохицуулалт хийсэн байгаа. Энэ бол 79 оноос хойш төрсөн иргэдэд хамааралтай. Гэхдээ энд мэдээж зохих хэмжээний нэлээн сайжрал харагдана гэж үзэж байгаа. Яагаад гэхлээр энд нэрийн дансныхаа үлдэгдлийг даатгуулагч өөрөө хянаад, тэгээд мөн хүү тооцоод ингээд явж байгаа. Тэгэхээр эндээс эхлээд нэг улс төрийн шийдвэр гарсан ч гэсэн нөлөөлөхгүй. Яагаад гэвэл хувь хүний шууд харагдаж байгаа нэрийн данс руу нь гар дүр хүрэх боломжгүй болоод явчих болов уу гэж үзээд байгаа. Баярлалаа.

Л.Энхнасан: Баяраа гишүүн 5 дугаар микрофон.

Б.Баяраа: Ер нь нийгмийн даатгалын явж ирсэн зам мөр маань, сангийн бүрдүүлэлт маань тийм тодорхой, цэвэр байгаагүй юм шиг байгаа юм. Зүгээр ганцхан бохир жишээ дурдахад л ухаандаа Капитал банкны яг тухайн удирдлагууд дээр ямар хэмжээнд арга хэмжээ аваад өнгөрөв гэж харахлаар үнэхээр нөгөө даатгуулагчдын сэтгэл санаагаар тоглодог юм шиг ийм л юм харагддаг. Шүүх засаглалдаа ч бохир нь байгаа байх, улс төрийн оролцоо нь ч байсан байх. Тэр утгаараа бидэнд яг ард түмэнд бол тэгж харагддаг. Тэгэхлээр 24 оноос өмнө бас ч асуудалтай явжээ, 24 оноос хойш.../минут дуусав/

Л.Энхнасан: Нэмж хариулна уу, Баяраа гишүүн 5 дугаар микрофон.

Б.Баяраа: Олон нийтийн хяналтын зөвлөлтэй боллоо, мэргэжлийн хороодтой боллоо, хуулиар зохицуулах зохицуулалттай боллоо. Энэ маань өсөлт дэвшилтийн нэг том юм. Харин энэ хуулийг илүү боловсронгуй болгох гэж оролцох нь хамгийн чухал. Жишээлбэл хэдэн гишүүд ямар нэг өнцгөөр өөрсдөдөө таалагдсанаар эрх мэдлийн дагуу хуулийг өөрчилдөг байгаад, тэрийгээ янз янзын шуурхай горимоор оруулж байгаад батлуулдаг болчихвол энэ өөрөө нөгөө л аюулын харангыг дэлдэнэ. Тийм учраас оролцоог нь өргөжүүлэх, эртүүдхэн телевизээр Сансармаа гишүүн маань хэлж байсан. Ажил олгогчид маань нэг их шимтгэл төлөхөөсөө зугтаагаад байдаггүй юм билээ. Харин тэрийг оролцоог нь

өндөржүүлж, шударга тогтолцоонд оруулж, тэр төлдөггүй нэг нь төлдөг байх энэ зарчим нь илүү чухал. Цаашдаа ч бид.../минут дуусав/

Л.Энхнасан: Аубакир сайд нэмж хариулна уу.

Т.Аубакир: Баярлалаа. Бат-Эрдэнэ гишүүний асууж байгаа асуулт яах арга байхгүй чухал л асуулт л даа. Яг ний нуугүй хэлэхэд сая манай зөвлөлийн гишүүд ч хэлж байна. Нийгмийн даатгалын тогтолцоо нь өөрөө буруу биш. Энэ хуримтлалын явцад энэ түүхэн он хугацааны үед зарцуулалт буруу байсан, сая жишээ хэлж байна. Янз бүрийн арилжааны банкнууд дээр мөнгөө байршуулаад алдсан. Мөн үүнтэй зэрэгцээд улс төржсөн ийм салбаруудыг хэт хөнгөлөлттэй энэ нийгмийн даатгалын шимтгэлийг нь хөнгөлж өгдөг, шинэ хууль санаачилдаг гэх зэрэг янз бүрийн сөрөг нөлөөллүүд бий. Хамтын хариуцлагын тогтолцоо гэдэг өөрөө тийм айхтар муу тогтолцоо биш. Яг өнөөдрийн хувьд нийгмийн даатгалын энэ тогтолцоо маань өнөөдөр улсын төсвөөс 1,4 их наяд төгрөгийн татаастай явж байгаа. Энэ маань 30 он гэхэд бараг 2 дахин.../минут дуусав/

Л.Энхнасан: Сайд гүйцээж хариулна уу.

Т.Аубакир: Одоогийн яг улсаас авч байгаа татаас 1,4 их наяд төгрөгийн татаас авч яг өнөөдөр тэтгэвэр авч байгаа хүмүүсийнхээ тэтгэврийг бүрэн гүйцэд тавиад явж байгаа. Бид энэ тогтолцоогоо ялангуяа энэ 126 гишүүнтэй болсон үед бид зоригтойгоор реформ хийхгүй бол үндсэндээ 2030 он хүрэх үү үгүй юу яг энэ тогтолцоо маань бид эргээд 2030 оноос хойш тэтгэврээ тавихад маш хүндрэлтэй болно. Бид яг үнэн байдалтайгаа нүүр тулах хэрэгтэй. Тийм учраас нийгмийн даатгалын тогтолцоонд зоригтой реформ хэрэгтэй. Реформ хийхэд тэр шилжилтийн зардал нь маш их өндөр гарч байгаа. Одоо яг ингээд хүчин төгөлдөр тэтгэврээ аваад явж байгаа яг өнөөдрийн тэтгэвэр, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч хоёрын харьцаа үндсэндээ математикийн хувьд алдаатай болж эхэлсэн гэдэг нь л тодорхой болчихож байгаа л гэж хэлье.

Л.Энхнасан: Бат-Эрдэнэ гишүүн тодруулга хийе.

Б.Бат-Эрдэнэ: Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл би тэр гишүүдийн асуудал орж ирж байхад Байнгын хороон дээр хэлж байсан. Нийгмийн даатгалын сан дампуурах, мөнгөгүй болох, ашигт бус алдагдал та бүхэн хариуцлага хүлээх үү гэж би 1 дүгээрт асуумаар байна?

2 дугаарт ер нь зүгээр энэ иргэд, аж ахуйн нэгжийн итгэл хүлээсэн тогтолцоо л эвдэгдчихсэн байхгүй юу Нийгмийн даатгалын сан дээр. Сангийн хөрөнгийг үр ашигтай, ил тод удирддаг систем нь байхгүй байхгүй юу. Тийм учраас хулгай нүүрлэж байгаа юм. Тийм учраас энд тэндхийн банканд аваачиж очсон сайд нь тавьж байгаа юм. Бид энэ хувь хүний мэдээлэл, шимтгэлийн нарийн бүртгэдэг ийм дэвшилтэт систем рүүгээ орох уу? Нийгмийн даатгал төлж байгаа, шимтгэл төлж байгаа хүн юуны төлөө нийгмийн даатгал төлөөд байгаа ил тод мэдээллийг авдаг цахимжсан систем рүү орох боломжтой юу гэдэг ийм 4 асуултыг би асуумаар байна.

Л.Энхнасан: Сайд нэмж хариулах уу? Та Зөвлөлийн гишүүн, дарга нь, Баяраа гишүүн хариулна уу, 5 дугаар микрофон.

Б.Баяраа: Хариулъя. Ер нь яг үнэндээ өчигдөргүй өнөөдөр, өнөөдөргүй маргааш гэж байхгүй. Бид яг өнөөдөр ажиллаж байгаа би бол жишээлбэл 22 оны 7

сард нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн болж орж ирсэн. Яг тэр цагаасаа хойш хариуцлага үүрэхэд бэлэн, хаана ч хэлнэ энийгээ, хариуцлагыг үүрнэ. Надаас шалтгаалаад, биднээс шалтгаалаад асуудал болоход. Гэхдээ бид урьд нь алдагдсан хүмүүсээс хэр зэргийн хариуцлага үүрэх вэ гэдэг юмыг бас л ярих ёстой. Миний түрүүний хэлдэг жишээ тэр Капитал банкны тэр олон тэрбум төгрөгийг устгачихсан хүмүүс ямар хариуцлага үүрэв нийгмийн өмнө. Ингээд ярихлаар бид тогтолцооноос гадна тогтолцоог хэрэгжүүлж явсан тэр хүмүүстэй.../минут дуусав/

Л.Энхнасан: Бусад гишүүд Сансармаа гишүүн 3 дугаар, 4 дүгээр микрофон.

Р.Сансармаа: Хариуцлага хүлээх үү гэж асууж байна. Бид 22 оноос сонгогдсон. Тэр сонгогдсон цагаасаа хойш нэлээн хариуцлага хүлээх бэлтгэлтэй, хариуцлага хүлээхүйцээр ажиллах ёстой гэж үзэж байгаа. Хамгийн түрүүнд нийгмийн даатгалын үндэсний зөвлөл биднийг сонгогдоход протоколгүй хуралддаг байсан. Энийг эсэргүүцэж, бид заавал протоколтой хуралддаг байх ёстой. Хэн, юу хэлж, хэн юуг зөв, буруу янз бүрээр ойлголцож байсан байна гэдгийг бичгээр хийсэн протоколоор бид гарын үсэг зурж байж баталгаажуулна гэдэг ийм байдлаар одоо манай хурал протоколтой явдаг болсон. 24 оноос эхэлсэн байх тийм ээ, бичгээр хийсэн протоколтой явдаг болсон. Тэгэхээр бид яах гээд ингээд байна гэвэл ерөнхийдөө хариуцлага дараа нь хэн хүлээх вэ гэдэг бол тод байх ёстой гэж. 2 дугаар юм гэвэл бас байгаа. Энэ яг сангийн чөлөөт үлдэгдлийг зүй зохистой.../минут дуусав/

Л.Энхнасан: Гүйцээж хариулъя. Сансармаа гишүүн 5 дугаар, 4 дүгээр микрофон.

Р.Сансармаа: Сангийн чөлөөт үлдэгдлийг зүй зохистой, цаашид ийм алдаа гаргахгүй байршуулж чадах уу гэж байгаа бол бас 24 оныхоо хуулиар бид олон нийтийн хяналтын зөвлөлтэй болсон. Хяналтын зөвлөлд маань туршлага бүхий, мэдлэг бүхий энэ салбарт олон жил ажилласан энэ доктор, профессор багш нар маань зөвлөж явж байгаа. Ингээд бид хэд нэлээн хариуцлага сайжирна, алдаа мадаг багасна гэж харж байгаа. Баярлалаа.

Л.Энхнасан: 2 дугаар микрофон Энхжаргал гишүүн. Энхжаргал гишүүн хариулъя. Уучлаарай 3 дугаар микрофон юм шиг байна.

Э.Энхжаргал: Бүгдээрэнд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Хариуцлага хүлээх үү гэдэг дээр мэдээж би бол 2021 оны 4 сард энэ нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр ажил олгогчийн төлөөлөл Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос орж ажилласан байгаа. Энэ хугацаанд, энэ хугацаанаас хойших хугацааны өөрсдийн гаргасан шийдвэр, тогтоол шийдвэр бүх л зүйл дээр хариуцлага хүлээж ажиллана гэж бид энэ гишүүнээр орж сонгогдоод ажилласан байгаа. Энэ хугацаанд бид нэлээдгүй ажлуудыг, нэлээдгүй олон тогтоол, шийдвэрүүдийг, орж ирж байгаа Капитал банк болон Чингис хаан банкнаас энэ өр төлбөрөө буцааж авах чиглэлээр гарсан нэлээдгүй олон тогтоол шийдвэрүүдийг гаргаж, хугацаа алдалгүй бид ажиллаж, шийдвэрүүдийг гаргаад явж байгаа гэж хэлмээр байна. Ер нь хариуцлагын тогтолцоо.../минут дуусав/

Л.Энхнасан: 3 дугаар микрофон нэмж хариулъя.

Э.Энхжаргал: 24 оноос эхэлж мөрдөгдөж байгаа энэ хуулийн хүрээнд нэлээн хариуцлагын тогтолцоог нэлээн сайн оруулж ирсэн гэж үзэж байгаа. Түрүүн яригдаж

байсан албан бус салбар нэлээд нэмэгдэж байна гээд. Энэ дээр санал нэг байна. Тэгэхлээр бид яг энэ нийгмийн даатгалын шимтгэлийг албан бус салбараас албан салбарт шилжих сонирхолтой байгаа жижиг бизнес эрхэлж байгаа энэ аж ахуйн нэгж, байгууллагуудын нийгмийн даатгалын шимтгэл дээр уян хатан бодлого барьж, арай бага шимтгэл төлөх байдлаар ингэж, тэгээд нөгөө орлого ашиг юу нь ингээд жигдрээд ирэхлээрээ яг бусад том компаниудынхаа адил ийм нийгмийн даатгалын шимтгэл төлөх энэ уян хатан бодлого руу орохгүй бол албан бус салбарт ажиллаж байгаа болон жижиг бизнесүүд энэ татвараас болоод энэ албан салбарт орохгүй байгаа юм байна гэдэг ийм судалгаа бол манай хийсэн судалгаагаар гарч ирсэн байгаа. Тийм.../минут дуусав/

Л.Энхнасан: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм орж ирэхэд шинэчилсэн дүрэм орж ирэхэд хариуцлага хүлээдэг байх ёстой гэдэг заалтыг оруулсан, тэр редакцын засвартайгаар оруулна гэж хэлсэн. Орсон болов уу гэж найдаж байгаа. 2024 оны өнөөдөр яг энэ хэлэлцэж байгаа асуудал дээр 520,5 тэрбум төгрөгт хүрээд, нийт өрийн хэмжээ 30,3 хувиар өссөн байгаа. Та бүхэн сая 21, 22 оноос хойш ажиллаж байгаа гэдгээ хэлсэн. Энийг үл шалтгаалсан байдлаар та бүхэнтэй хариуцлагын асуудлыг ярина гэдгийг би албан ёсоор 1 дүгээрт хэлмээр байна. Тэгээд бид энэ санал, дүгнэлт нэгэнт хэлэлцэж байгаа учраас, дүн шинжилгээг авч үзэж байгаа учраас энэ дээр та бүхэнтэй эргээд хариултуудаа их болгоомжтой хэлж байгаарай гэдгийг хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Эрдэнэбат гишүүн асуултаа асууна.

С.Эрдэнэбат: Асуугаад байвал их юм байна. Тэгээд 177 хуудас тайлан бэлдсэн байна, сайн байна. Тэгэхдээ энийг жирийн даатгал төлөгч ойлгодог байх хэрэгтэй. Даатгал төлөгчид, тэр ажил олгогчид ч гэсэн ойлгодог байх хэрэгтэй. Хаана хамаагүй бүх юмыг энд тэндээс татаж авчраад олон хуудастай байна гэхээсээ илүү миний төлж байгаа татвар хаана явна вэ, ирээдүйд хэдэн хүүгээр өсөж байна вэ гэдэг зүйл дээр маш тодорхой байх ёстой. Би тухайлбал 2023 онд байна уу бодлогын хүү 13 хувь байж байхад иргэдийн нэрийн данс дахь хуримтлагдсан үлдэгдэлд 9 хувийн хүү тооцох шийдвэрийг гаргасан. Энэ өөрөөр хэлбэл бодлогын үнээс доошоо ийм юуг бол тооцсон буюу одоо гадуур банкнуудаар бодлогын хүүгээс доошоо тийм хүү тооцдог хадгаламж гэж байхгүй л дээ. Тэгэхээр энэ тал дээрээ тайлбар өгнө үү гэдгийг би хэлмээр байна.

2 дугаарт 215 тэрбум төгрөг чөлөөт үлдэгдэл, мөнгөжүүлсэн үлдэгдэл гэсэн сайн байна. Энэ бол цаашаа ингээд үржээд явах ёстой. Одоо 4 хувь болгоно гээд ингээд тавьж байгаа. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн сан хамгийн ашигтай сан. Үндсэндээ 700 тэрбум төгрөг 4 банканд хадгалсан байна лээ. Тэгэхээр энийг та бүгд маань яг ямар зарчмаар хадгалав? Энийгээ олон нийтдээ нэг жоохон тавиад, энэ банк нь ийм гэдэг юмыг уг нь нээлттэй хуралдаад нэг шалгаруулчихдаг байгаарай гэж би захиж байсан. Цаашдаа иргэн миний мөнгийг хаана, хэдэн төгрөгөөр хадгалаад, миний нэрийн данс дахь мөнгө ИМонголиагаар ороход аль банканд, хэдэн хувиар өсөж байна вэ гэдгээ хардаг л болох ёстой байхгүй юу. Тэгээд одоо хүртэл яагаад ИМонголиа дээр энийг оруулж чадахгүй байгаад байна вэ гэдгийг би асуумаар байна?

2 дугаарт тэр малчны шимтгэлийг 50 хувиар төлсөн, хэдэн хүн өссөн бэ? Нөгөө малчид маань хэр зэрэг даатгуулж өсөж байна вэ? Нөгөө сэдлийг нь бий болгож чадаж байна уу, үгүй байна уу?

Нийгмийн даатгалын тухай хуультай холбоотой үндэсний зөвлөл маань жоохон чимээгүйхэн л байгаад байх юм. Оруулалтгүйгээр аваачиж хажуугаар нь хусчхаад байна л даа. Тийм учраас та бүгд маань нэг талаар энэ дээрээ идэвхтэй байх ёстой. Тэр улс төрчид гэдэг юм уу, тэр сайд дарга гэдэг юм уу, гишүүд гэдэг юм уу оруулж болно. Тэгэхдээ Үндэсний зөвлөлөөр энэ асуудал орохгүйгээр, ажил олгогчийн өмнөөс нэг хүн яриад, ажилтны өмнөөс нэг хүн яриад, тэгээд энийг ингээд ийш нь, тийш нь ингээд саваад байж ерөөсөө болохгүй. Энэ өөрөө маш эмзэг сан бөгөөд энийг бид тэр үндсэн нурууг нь алдвал эргээд засах гэж маш хүндэрнэ. 7 онд 19 хувийн нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч төлдөг байсныг 9 функтээр бууруулж байгаад ажилтан дээр нэмж байгаад, тэгсэн аравхан жилийн дараа юу болсон бэ гэхээр бид буцаад 5 функтээр бүгдийг нь нэмье л гэдэг ийм юм руу л тулсан шүү дээ. Тэгэхээр өсөх, буурах өнөөдрийн асуудал. Цаашдаа хэр зэрэг тогтвортой яаж явах вэ гэдэг дээр та бүгд мэргэжлийн байр суурийг бидэнд зөвлөх ёстой. Мэргэжлийн Байнгын хороонд зөвлөдөг байх ёстой, хэлдэг байх ёстой. Тийм учраас нэг тайлан тавих үеэр орж ирээд бусад үед нь алга болчихдог байж ерөөсөө болохгүй. 1 минутаа нэмээд нэг мөсөн авчихъя даргаа.

2 дугаарт энэ ажлын албан дээр байж байгаа хүмүүс яг ний нуугүй хэлэхэд аль алинд нь ... гэж хэлмээр байгаа. Үнэхээр тал бүрийн институтийг төлөөлж байгаа хүмүүс маань нэгэнт хариуцлага хүлээж.../минут дуусав/

Л.Энхнасан: 1 минут нэмэлт.

С.Эрдэнэбат: Томилж байгаа ажлын алба нь нэг сайд ажлын албаны дарга томилоод байж таарахгүй. Энэ би ямар хүмүүс байдаг юм байна. Одоо татварын хууль дээр ер нь нийгмийн даатгалын ажилтнуудыг цомхотгох, цөөлөх гэдэг асуудал хүртэл яригдаад эхэлж байгаа байх. Би энэ тайлангаас харлаа. 0,3-хан сая төгрөгөөр нөгөө даатгуулагч нартаа сурталчлах ажлыг хийсэн байна шүү дээ. Бүр 5 их наядын хэмжээний төгрөгтэй байж. Тэгэхээр энэ талын ажлууд яагаад ийм сул байгаад байгаа юм, эсхүл ийм юмыг тайлбарлахаас айгаад байдаг юм уу? Манай нийгмийн даатгалын юу чинь мянга хоёр, гурван зуу, зүгээр татвар хураах гэхээсээ илүүтэйгээр эргээд тэр хүмүүст ойлгуулах, тэр залуучуудад хэлж өгөх, тэр улс төрчид ч байдаг юм уу, тэр хэвлэл мэдээллээр зөндөө л харж байгаа байлгүй. Ийм ажлууд чинь жоохон дутмаг байгаад байна шүү. Тийм учраас энэ тал дээр яагаад ийм бага мөнгө зарцуулдаг, зарцуулсан юм бэ гэдгийг хэлмээр байна.

Тэгээд хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна 270 тэрбум төгрөг. Энэ дээр тодорхой тайлбарыг өгөөч.

Л.Энхнасан: Гишүүдээс хэн хариулах вэ? Сансармаа гишүүн 5 дугаар микрофон, 4 дүгээр микрофон.

Р.Сансармаа: Сая бид хариуцлагын тухай ярьсан. Бидэнд хуулиараа хүлээсэн үүрэг, хариуцлага байж байгаа. Яг энэ үүрэг, хариуцлагынхаа хүрээнд бид нөгөө ажлынхаа үүргийнхээ үндсэн чиг үүргийнхээ хүрээнд хариуцлагаа хүлээнэ гэдгээ энүүгээр нэг тодруулчихъя. Тэгээд бид яах вэ нэрийн дансны хүүг гол төлөв яаж тогтоогоод байна вэ гэвэл бид хадгаламжийн хүүгээсээ ямар ч байсан нэрийн дансанд өгөх гэж амлаж байгаа хүү маань бага байх ёстой гэж үзээд байгаа.

Тэгэхгүй бол бид өнөөдөр хадгаламждаа системийн 5 банканд мөнгөө хийдэг, тэгэхдээ мэдээж нэлээн хэлцэл болж байж, хүүгээ тогтоогоод өгч байгаа. Тэр хүүгээс нэрийн дансны хүү бага байх ёстой гэж үзэж байгаа. Яагаад гэвэл бид ирээдүйдээ худлаа амлах ёсгүй гэж үзэж байгаа. Өөрсдийнхөө олж байгаагаас ихийг амлаж худлаа хуурахгүй байх ёстой гэж үзэж арай бага мөнгө дээр хүүг тогтоож байгаа, хурлуудын протокол дээр энэ тэмдэглээтэй байж байгаа.

Тэгээд нийгмийн даатгалын хуулийн тухайд яривал үнэхээр хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд эсвэл хуулийн саналуудыг үндэсний зөвлөлийн гадуур өнгөрөөсөн. Сая 2024 онд батлагдсан хуулийг яг биднээс санал аваагүй. Нэлээн олон хэлэлцүүлэгт сайн дураараа очиж санал өгсөн боловч хүлээн авах нь нэлээн тааруу байсан. Харин саяын нэмэлт дээр Энх-Амгалан сайдын үеийн хийгдсэн нэмэлт дээр нэлээн олон саналуудыг шингээж авсан байж байгаа.

Тэгээд даатгуулагчдаа сурталчлах тал дээр яагаад ийм бага мөнгө зарцуулсан юм бэ гэж байна. 12 дугаар зүйл дээр сангийн зардал хэсэг байгаа. Энэ дээр бид үндэсний зөвлөлийн гишүүдийн хувьд маш болгоомжтой хандаж байгаа. Тэр тусмаа сурталчлах зардлыг, сурталчилгааны зардлыг аль болох бага байх ёстой, тааз нэг тогтоох ёстой гэж үзээд байгаа. Яагаад гэвэл манай нийгмийн даатгал маань албан журмаар буюу нэгэнтээ компани байгуулсан бол шууд нийгмийн даатгал төлөх үүрэг хүлээдэг. Ийм байхад сурталчилгааны зардлыг хэт өндөр байлгаж болохгүй, энэ бол санд зардал өсгөх аюултай гэж үзээд бид аль болох зардлаа, тэр тусмаа хуульдаа бол одоо тогтоогоогүй байгаа энэ яг зар сурталчилгаанд 41 дүгээр зүйлд зориулах энэ зардлаа таазыг нь 1 юм уу, 2 юм уу хувь зааж тогтоогооч. Тэгэхгүй бол энэ дараа нь хариуцах, хэн хариуцах юм бэ гэдэг ийм асуудлыг бид ярьж байгаа. Баярлалаа.

Л.Энхнасан: Тодруулга Эрдэнэбат гишүүн 1 минут.

С.Эрдэнэбат: Яах вэ би яг тэр хариулж байгааг чинь гайхаад байна л даа. Бид нөгөө даатгал төлөгчийнхөө мөнгийг яаж илүү өсгөх вэ гээд байхад та яаж багаар тавих вэ, худлаа амлахгүй энэ тэр гээд ингээд арилжааны банкнуудын өмнөөс ярьж байгаа юм шиг ингээд ярьж болохгүй. Би бодлогын хүү ярьсан, арилжааны банкны дундаж хүү яриагүй байхгүй юу. Бодлогын хүү гэдэг бол өөрөөр хэлбэл хамгийн доод талын хүү.

2 дугаарт тэр даатгуулагч нарын мөнгийг өөрсдөд нь мэдэх эрхийг нь олгохын тулд мөнгө хэмнээд бид энэнээс болгоомжилж байгаа энэ тэр гэж ярьж болохгүй шүү. Өөрөөр хэлбэл нийгмийн даатгалын хуулийн маш олон реформ шинэчлэлийг хийсэн юм. Энэ Ганцэцэг дарга энэ тэр бол мэдэж байгаа, Батжаргал эд нар бол. Энийгээ сурталчлаад ингээд ийм болсон шүү, мөнгөө хэр зэрэг олон хадгална вэ тэр хэмжээгээр чинь таны ирээдүйн тэтгэвэр чинь хийнэ гэдэг юмыг энийг хийхгүй болохоор чинь энэ залуучууд нийгмийн даатгал дээрэм гээд яриад суугаад байх нь аргагүй шүү дээ. Тэгэхээр үндэсний зөвлөлийн гишүүд ингэж даатгуулагч нарынхаа мэдэх эрхийг хязгаарласан болгоомжилж байгаа энэ тэр гэж ярьж болохгүй. Би зүгээр арай өөр утгаар хэлэх гээд буруу ярьчихав уу гэж бодож байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Баярмаа гишүүн асуултаа асууна.

Ж.Баярмаа: Магадгүй сайдыг байхад асуух ёстой байсан ч байж магад. Гэхдээ бид чинь нөгөө татвар төлөгчдийн мөнгийг гарын салаагаараа урсгах тухай асуудлыг маш их ярьж байгаа. Урсгадаг, урсгаж байсан тухай асуудал. Үүнээс гадна

яг нөгөө өөрсдөө хэрэглэх гээд уг нь хөөрхөн нийгмийн даатгалын шимтгэл болгоод төлчихсөн энэ мөнгийг нь аанай л нөгөө банкнуудад байршуулаад бас алга болгочихсон ийм асуудал зөндөө яригддаг. Тэгээд энэ аудитын тайлангаас харахад нийгмийн даатгалын сангийн бөгөөд энэ эрүүл мэнд, эрүүл мэндийн сан ороогүй. Нийгмийн даатгалын сангийн авлагын үлдэгдэл 726,7 тэрбум төгрөг гэж энд байна л даа. Тэгээд өмнөх оноос 46,2 тэрбумаар өссөн гэж байгаа юм авлага. Авлага талдаа мөнгөн хөрөнгийн. Гэтэл одоо энэ чинь зүй нь бол аль болох авлагаа барагдуулаад, энэ авлага тал чинь ингээд дүн нь багасаж байх ёстой атал бүүр ингээд жил ирэх тусам тэрбум тэрбумаар нэмэгдээд, 46 тэрбумаар нэмэгдэнэ гэдэг маш их дүн шүү дээ. Тэгэхээр энэ авлага барагдуулах ажлууд хэр явагдаж байгаа вэ?

Тэгээд сая жишээлбэл зүгээр энэ Капитал банк, Чингис банк гээд л тэгэхэд сая дөнгөж, дөнгөж сая Эрдэнэбат гишүүн ярилаа л даа. Нөгөө бодлогын хүүгээс доогуур хүүгээр энэ тэр байршуулчихсан гээд гэх мэтийн асар хууль бус олон зүйлээс үүдээд энэ их олон тэрбум төгрөгийн авлага ингээд үүсчихсэн, шамшигдчихсан байгаад байдаг. Гэтэл авлага барагдуулах ажил маш удаашралтай, нэмж ингээд өрөнд ороод, нэмж ингээд өрөнд орж байна гэсэн үг шүү дээ. Тэгээд авлага авах нь буурахгүй, авлага нь ерөөсөө буурахгүй, нэмэгдээд байдаг. Хаана, ямар өр, ямар асуудал үүсээд энэ их авлага барагдах биш, нэмэгдээд байгаа юм бэ? Тэгээд барагдуулах тал дээр ямар ажлууд хийж байгаа юм бол дорвитой?

Л.Энхнасан: Батжаргал дарга хариулах байна 1 дүгээр микрофон.

Б.Батжаргал: Баярмаа гишүүний асуултад хариулъя. НДЕГ Б.Батжаргал. Нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлтэй авлага 2 ангилагдана. 1 дүгээрт нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, аж ахуйн нэгж, байгууллагуудаас төлөх ёстой нийгмийн даатгалын шимтгэл гэсэн үг. Энэ авлага бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 520 тэрбум төгрөгтэй байгаа. Тэгээд бид энэ авлагыг барагдуулахын тулд бүх аж ахуйн нэгжтэй очиж 1 дүгээрт очиж уулзалт хийдэг. Яагаад төлөхгүй болчхов, юу болчхов, яачхав, гэрээ байгуулъя, хуваарь гаргая гээд явдаг. Хуваарь гаргаад төлөөд явбал бид тэгээд төлүүлээд л дуусгачихна.

2 дахь авлага бол 2 банкны авлага Капитал ба Чингис банкны 2 авлага байгаа. Энэ 2 авлага хамгийн гол асуудал нь 2016 онд тухайн үед сайд байсан хүн сайдаа өгөөд буугаад явахынхаа өмнө 2 жилээр сунгаад хаячихсан учраас бид 2 жилийн дараа шүүхэд өгөх эрх нь нээгдээд, маш хүнд байдалд орсон. Тэгэхдээ бид зүгээр байсангүй. Капитал банкны хувьд 104 тэрбум төгрөгөөс бид 38,8 тэрбум төгрөгийг төлүүлсэн, одоо 65,4 тэрбум төгрөгийн авлагатай байна. Чингис хаан банкны хувьд 103,6 тэрбум төгрөгийн анхны гарааны авлагатай, энэнээс 14,2 тэрбум төгрөгийг төлүүлсэн. Одоо 89,4. Өнөөдөр бэлэн төгрөгөөр 1 тэрбум төгрөг төлөгдөж байна. Ингээд 88,4 тэрбум төгрөгийн авлагатай байгаа. Бид энэ дээр бүхэл бүтэн 1 нэгжийг яг энэ 2 банкны авлагын төлөө гаргаад ингээд энэ дээр жишээ нь авлагын араас ингээд явуулж байна. Тэгээд бид нэг шинэ хуулиар манай нэгжүүд байна хуульчтай болсон. Тэгээд хуульчдыг энэ шимтгэлийн өр авлагын араас өдөр, шөнөгүй, зогсоо зайгүй л явуулж байна. Тэгээд авч болох бүх л арга хэмжээ бидэнд юу байна тэрийгээ л бид хийж байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Тодруулга Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: 512 орчим тэрбум нь аж ахуйн нэгжүүдээс авах авлага. Тэгээд энэ бол бас л нэг юмыг хэлж байна л даа. Энэ яах вэ ер нь энэ Нийгмийн бодлогын байнгын хороо учраас энэ их өрөнд орчихсон байна шүү дээ аж ахуйн нэгжүүд маань нэг талдаа. Гэтэл та нар ингээд авлагатай, тэгээд авлагаа аваач, авлагаа цуглуулаач гээд бид шахаад байдаг. Гэтэл нөгөө талдаа хөөрхий нөгөө аж ахуйн нэгжүүд чинь ямар ч аргагүй байдалд орчихсон байна шүү дээ. Тийм ч учир бид нөгөө нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ чинь ямаршуу байгаад байгаа юм бэ, эргэж харах юм биш үү. Цаана нь нөгөө аж ахуйн нэгжийн орлогын албан татвартаа идүүлж гүйцлээ, тэгээд нийгмийн даатгалын шимтгэлд идүүлж гүйцлээ гээд ингээд нөгөө талдаа нэг ийм юм яриад байдаг. Энэтэй холбоотой асуудлыг гишүүд маш их сөхдөг. Гэтэл энэ талдаа асар их хэмжээний авлага үүсчихсэн, барагдах нь тодорхойгүй шахам болчихсон ийм л dilemma гэдэг шиг ийм хүнд нөхцөлд л орчихсон байна л даа манай энэ салбар гэдгийг л хэлэх гэсэн юм. Тэгээд.../минут дуусав/

Л.Энхнасан: Баярлалаа. Чуулган манай Байнгын хороодын гишүүдийг хүлээгээд байгаа учраас жоохон хурдан шуурхай яваад байгаа шүү. Баясгалан гишүүн асуултаа асууна уу.

Ж.Баясгалан: Бүгдээрэнд нь энэ өдрийн мэнд хүргэе. Гишүүд маань ер нь энэ өр авлагын талаар их асуулаа. Энэ бол яг зайлшгүй гарах асуулт учраас давхацчихлаа. Тэгэхлээр би 3 юм асууя. 1 дүгээрт нь нийгмийн даатгалын сангаас эрүүл мэндийн даатгалын санд төлөх эцсийн үлдэгдэл 89,7 тэрбум төгрөг байгаа. Тэгэхлээр энэ ондоо багтааж өгөхөөр тохирсон гэж ойлгосон. Тэгэхлээр энэ мөнгө маань ямар эх үүсвэрээс өгөх юм бэ? Нийгмийн даатгалын сангаас буюу нийгмийн халамжийн салбараас, хамгааллын салбараас нэг удаадаа шууд 89,7 тэрбум төгрөг гарах тийм эх үүсвэр байгаа юу, 2025 оны төсөвт энэ мөнгө өөрөө суусан уу эхний асуулт?

2 дахь асуулт энэ тайлант жилийн хугацаанд сайн дурын даатгалд даатгуулсан 51,5 мянган малчны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ноогдох тэтгэврийн шимтгэлд 24,4 тэрбум төгрөг улсын төсвөөс гаргаад төлсөн. Тэгэхлээр малчдын тэтгэврийн насыг 5 насаар наашлуулсан, даатгалын шимтгэлийг нөхөн тооцох хуулийг 3 ч удаа сунгасан, улсын төсвөөс 50 хувийг нь хариуцан төлж байхад малчдын сайн дурын даатгалд хамрагдах энэ хамрагдалт их муу байна, бага байна гэсэн дүгнэлт гарсан байна, хангалтгүй байна. Тэгээд энэний гол юм нь юу вэ гэвэл малчдын идэвх сул байна, мэдээлэл, ойлголт дутмагтай холбоотой гэж тайлбарласан байсан. Тэгэхлээр яг энэ талаараа та нар ямар арга хэмжээ авч, энэ бид нэгэнт энэ өнгөрсөн 24 оны юмыг ярихаасаа илүү ирээдүйдээ яах вэ гэдгээ ярих ёстой. Тэгэхлээр 25 ондоо энэ хамрагдалтын хувь хэмжээг нэмэгдүүлэх талаар ямар арга хэмжээ авахаар төлөвлөсөн байгаа вэ? Энэ 2 дахь асуулт шүү.

3 дахь асуулт мэдээж бид энэ парламентын хувьд ярьж байгаа хууль тогтоосон хууль тогтоомжоосоо илүү давсан журмууд гараад байна, тогтоолууд гараад байна, энийг багасгая гэж ярьж байгаа. Тэгвэл 2023 онд ер нь 55 журам баталсан байгаа. 2024 онд болонгуут Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо, Засгийн газар Нийгмийн даатгалын даргын тушаал гээд хамтарсан шийдвэрээр 22 эрх зүйн баримт батлагдсан байна. Тэгэхээр энэ хуулиас давсан журмын харилцаа нь хүний эрхэнд халдаж байж болзошгүй гэдэг ийм асуудлыг бид байнга л ярьж байгаа шүү дээ. ЗГ-аас ч гэсэн нийтээрээ дагаж мөрдөхөөр гаргасан захиргааны хэм хэмжээний акт буюу бичил хуулийг 2 дахин багасгая гэлээ. Тэгвэл нийгмийн даатгалын багц хуульд одоо өргөн мэдүүлж байгаа.../минут дуусав/

Л.Энхнасан: 1 минут нэмж өгье.

Ж.Баясгалан: Энэ хуульд боломжтой дүрэм журмуудаас цөөлж оруулах тийм заалтууд байгаа юу? Бид энэ дүрэм журмуудаа багасгахын тулд энэ асуултыг асууж байгаа юм шүү. Тэгээд яг хуулиараа явбал хүний эрх зөрчигдөхгүй, ямар нэгэн хэм хэмжээ зөрчигдөхгүй байх тийм талтай. Энэ 3 дээр тодорхой хариулаад өгөөрэй. Баярлалаа.

Л.Энхнасан: Батжаргал дарга 2 дугаар микрофон.

Б.Батжаргал: Баясгалан гишүүний асуултад хариулъя. НДЕГ Батжаргал. Эрүүл мэндийн даатгалын сан нийгмийн даатгалын сангаас 2017 онд салаад, ЭМЯ-ны харьяанд очсон байна. Одоо ингээд бид манай байгууллага бол аймаг, сум, дүүрэгт нэгжтэйн хувьд орлогыг нь цуглуулж өгөх үндсэн үүрэгтэй хуулиар хүлээсэн үүрэгтэй. Түрүүн Баярмаа гишүүний дурдсан тэр 520 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага дотор байгаа тэр дүн нэг дүн бол 89 тэрбум буюу ЭМД-ын шимтгэлийн тооцоолол байгаа. Тэгээд ямар эх үүсвэрээр зарцуулах вэ гэхээр бид аж ахуйн нэгжүүд шимтгэлээ төлчихвөл бид 7 хоногтоо багтаагаад Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар луу шилжүүлдэг. Өнөөдөр гэхэд бид 3,4 тэрбум төгрөгийг жишээлбэл шилжүүлсэн.

2 дахь асуултын хувьд малчдын хувьд хамралт маш бага байгаатай санал нийлж байна. Энийг олон улсын байгууллага та нар 30 жил ингээд хамруулж чадсангүй, ингээд энэ шимтгэл хуваалцах ийм хөтөлбөрийг хэрэгжүүлчихвэл их зүгээр юм биш үү гэсэн санал тавьсан. Тэгээд энэ саналыг бид аваад 2024 оныхоо, 23 онд батлагдсан багц хуульдаа тусгаад ингээд нэг жил явлаа. Тэгээд өнгөрсөн онд яах вэ үр дүн бол 5 мянгаар нэмэгдсэн. Гэхдээ өмнө нь 100 хувиар төлдөг байсан малчид бол бүгдээрээ 50 хувиар төлье, төлье гээд л ороод ирж байгаа ийм шилжилтийн нэг ийм үе таарлаа. Тэгэхдээ малчдын 50 хувийг төлдөг хөтөлбөртэй адилхан хөтөлбөр манайд декреттэй ээжүүд дээр байдаг. Декреттэй байх хугацаандаа сайн дурын даатгуулагч эхийн 50 хувийг төсвөөс төлдөг хөтөлбөр байна. Цаатангийн шимтгэлийг улсын төсөв хариуцдаг хөтөлбөр байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ хараад гэртээ байгаа эцэг, эхийн шимтгэл, тэтгэврийн даатгалын шимтгэлийг төрөөс даадаг ийм хөтөлбөр байна гээд. Ингээд 6, 7 ийм хөтөлбөрийг манай улс ингээд, манай байгууллага бол хуулийн дагуу хэрэгжүүлээд явж байна.

Журмын хувьд нийтдээ нийгмийн даатгалын багц 4 хуулиас бүрдэнэ. Энэ 4 хуулийн харилцаа бол 1 сая хүнийг хамарна, 800 мянган тэтгэвэр, тэтгэмж авагчийг хамарч байгаа нэлээн том харилцаа. Үйлчилгээний хувьд 34 үйлчилгээ байгаа. 6 хэлэлцээр байна. Тэгээд нийтдээ 66 ширхэг тийм захиргааны хэмжээний акт батлагдсан. Бүгдийг нь Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн. Тэгэхдээ ХЗДХЯ болон ЗГ-аас журмуудаа цөөлөх гэсэн арга хэмжээн дээр яам өнгөрсөн онд чиглэл өгөөд, бид нэлээн олон журмууд дээр үнэлгээ хийгээд, заримыг нь хууль руугаа оруулах боломжтой юм байна гэсэн саналаа хүргүүлчихсэн байгаа. Баярлалаа.

Л.Энхнасан: Мөнхтуяа гишүүн асуултаа асууна уу.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Манай гишүүд ер нь бүгдээрээ л яг энэ тоо судалгаан дээр ач холбогдол өгч, анализ хийж байна л даа.

Энэ зээл дээр. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 24 оны үйл ажиллагааны тайлантай холбоотой 2 асуулт байна. 1 дүгээрт Капитал банкны эрх хүлээн авагчаас 104,2 тэрбум төгрөг нэхэмжилсэн бөгөөд 24 оны байдлаар 13,4 тэрбум төгрөгийг мөнгөн хэлбэрээр, 25 тэрбум төгрөгийг 78 ширхэг ширхэг үл хөдлөх хөрөнгө хүлээн авч нийт 38,5 тэрбум төгрөгийн төлбөр барагдаж, 65,7 тэрбум төгрөгийн үлдэгдэл байгаагаас Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан 62 тэрбум, Ажилгүйдлийн даатгалын сан 3,7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна гэсэн тайланд дурджээ. Энэ үлдэгдэл мөнгөө хэзээ, хэрхэн авч дуусгаж, энэ сангуудыг өр авлагагүй болгох вэ 1 дүгээрт? 2 дугаарт ийм их хэмжээний авлага үүссэн Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн даатгалын сан, Ажилгүйдлийн даатгалын сангууд дээр ямар, ямар эрсдэл бий болоод байгаа вэ? Энэ талаар сонсмоор байна?

2 дугаарт Капитал банкны эрх хүлээн авагч болон Чингис хаан банк хувьцаат компаниас нэхэмжилсэн өр төлбөрийг барагдуулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 24 оны А/68 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, Капитал, Чингис хаан банкны өөрийн болон зээлийн барьцаанд байгаа нуугдмал хөрөнгийг олж илрүүлэн нийгмийн даатгалын санд учирсан хохирлыг арилгах, нэхэмжилсэн өр төлбөрийг бүрэн барагдуулахад хамтран ажиллах хүсэлтийг Улсын ерөнхий прокурорт гаргаж, Авлигатай тэмцэх газарт холбогдох нэмэлт тайлбар, мэдээлэл, материалуудыг хүргүүлсэн гэсэн тайланд дурдсан байна. Энэ прокурор, Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт ямар шатандаа явж байна вэ, учруулсан хохирлуудыг нөхөн төлүүлэх боломж бололцоо хэрхэн гарч байна вэ гэдгийг сонирхож асууж байна?

Мөн НДЕГ-ын 24 оны санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлантай холбоотой нэг асуулт байна. Чингис хаан банканд байршиж байсан нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө өмнөх оны үлдэгдэл 94 тэрбум 916 сая төгрөгөөс тайланд 2024 онд 1 тэрбум 517,7 сая төгрөг буюу 1,6 саяыг барагдуулж, үлдэгдэл 93 тэрбум 399 сая төгрөгийг авч, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна. Капитал банканд байршиж байсан нийгмийн даатгалын сангийн мөнгө нь 68 тэрбум 201 сая төгрөгийн өмнөх оны авлагын үлдэгдлээс 3,7 хувь буюу 2,5 тэрбум төгрөгийг барагдуулж, үлдэгдэл 65,7 тэрбум төгрөгийг барагдуулах ажил удаашралтай байна гэх мэт дүгнэлтүүд гарсан байна. Тэгээд энэ нийгмийн даатгалын сангийн өр авлагыг яаж яаралтай дуусгаж, Капитал банк, Чингис хаан банкнаас авах.../минут дуусав/

Л.Энхнасан: Батжаргал дарга 2 дугаар микрофон, 1 дүгээр микрофон.

Б.Батжаргал: Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя. Капитал банкнаас авах авлага бол одоо 65 тэрбум байгаа. Өнгөрсөн оны сүүлээс эхлээд прокурор болон АТГ-тай хамтраад нуугдмал хөрөнгийн талаар хүсэлт бид удаа дараа яамнаас болон бид манай өөрийн зүгээс олон удаа гаргалаа. Тэгээд яг өнөөдрийн байдлаар бидэнд яг ирүүлчихсэн байгаа хөрөнгө бол 1,2 тэрбумын үнэлгээтэй 9 төрлийн хөрөнгийг илрүүлээд, манай газарт ингээд авах уу гэсэн байдлаар юу ч гэсэн бид Үндэсний зөвлөлөөрөө хэлэлцүүлэгт ингээд бэлдэж байна, саналаа хүргүүлчихсэн. Энийг авбал тодорхой хэмжээгээр буурна. Өнөөдрийн байдлаар Чингис хаан банкны хувьд 89 тэрбум төгрөг байснаас өнөөдөр бэлэн мөнгөөр 1 тэрбум төгрөг төлөгдсөн. Энэ бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай бид өнгөрсөн сард энэ өр төлбөрийг яаралтай барагдуулах чиглэлээр нэг Санамж бичиг байгуулаад, бүх аймаг, дүүрэгт нь жаахан ажиллагаанд оруулсан. Тэгээд энэний хүрээнд энэ 1 тэрбум төгрөг орж ирж байна. Бага мөнгө ч гэсэн тодорхой дүнгээр

буурч байгаад их баяртай байгаа. Нийтдээ 8 төрлийн 2,4 тэрбум төгрөгийн нуугдмал хөрөнгийг Авлигатай тэмцэх газар, прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага илрүүлээд манайд хүлээлгэж өгсөн.

Бид Үндэсний зөвлөлдөө танилцуулаад, энэ хөрөнгийг аваад, ингээд барагдуулаад энэ Үйлдвэрлэлийн ослын сан, тэтгэмжийн, Ажилгүйдлийн даатгалын санг хохиролгүй болох ийм ажлуудаа үргэлжлүүлж хийнэ гэсэн төлөвлөгөөтэй байна. Ер нь хамгийн хүнд байгаа энэ 2 банкны гол асуудал нь нуугдмал хөрөнгөө ерөөсөө бидэнд эрх мэдэл байхгүй нийгмийн даатгалын байгууллагад. Тэгээд бидэнд ерөөсөө очиж уулздаг газар 1 дүгээрт АТГ, 2 дугаарт прокурор, 3 дугаарт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар гэсэн 3 газарт л бид бараг худлаа хэлсэн хүнд 7 хоног болгон очиж уулзаж байгаа, одоо юу болж байна, хөрөнгө хаана байна, илрүүлэлт юу болж байна гээд уулзаад л яваад байгаа. Энэ дээр тусгай ажлын хэсэг гаргаад, тусгай нэгж ингээд байнга ажиллуулаад явуулж байгаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Би нэг асуулт асуучихъя. Тайлан бол Чингис хаан, Капитал банктэй холбоотой энэ хязгаарлагдмал санал, дүгнэлт гарсан байна. Мөн энэ олон жилийн насжилттай энэ 6 тэрбум төгрөгийн авлага барагдуулаагүй байна гэж байгаа юм. Тэгээд тайлангаа сайн харахад дампуурсан болон татан буугдсан 7 банкны нийт 5 тэрбум, 5.446 сая төгрөг. 16 аж ахуйн нэгжийн нийгмийн даатгалын 909 сая төгрөгийн авлага, тухайлбал Нийслэлийн өмчийн газар 552 сая төгрөг, Өндөр гэгээн ХХК 11 сая, үгүй ээ 111 сая, Дорнынговь ХХК 150 сая төгрөг гэж байна. Мөн 15 иргэдийн нийгмийн даатгалын 88 сая төгрөгийн авлага тус тус байна гэж байна. Тэгээд аудитаас олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй энэ иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас авах авлагыг 20-оос доошгүй хувиар бууруулах албан шаардлага хүргүүлсэн байна гэж байна. Ер нь энэ дээр ямар ажил хийгдэж байгаа, яагаад арга хэмжээ авахгүй байна вэ? Энэ чинь санхүүгийн бодлогын баримт бичгээрээ үнэхээр ингээд найдваргүй байгаа бол энэ авлагыг бууруулах ёстой шүү дээ. Энэ дээр Үндэсний зөвлөл хариулж өгнө үү? Төр-Од гишүүн. 7 дугаар микрофон.

Л.Төр-Од: Ажил олгогчийг төлөөлсөн гишүүн Төр-Од. Миний хувьд илүү банк санхүү, хөрөнгө оруулалтын салбарт олон жил ажиллаж байсан учраас энэ тал дээр илүү анхаарч ажиллаж байгаа. Ер нь эргээд яах вэ манай НДЕГ-ынхан илүү хууль сахиулах байгууллагуудтай шууд тулж ажиллаж байгаа. Үндэсний зөвлөлөөс бид ямар шаардлага тавьж байна вэ гэвэл эргээд ялангуяа бидний үед 3 банк дээр асуудал байсан. Үндэсний хөрөнгө оруулалт, Капитал, Чингис хаан банк гээд. Ямар ч байсан Үндэсний хөрөнгө оруулалтын банкны авлагыг бид бүрэн барагдуулсан. 2 дугаарт бид системийн нөлөө бүхий банканд энэ нийгмийн даатгалын сангийн эх үүсвэрийг байршуулж байя гээд энэ маань ороод бидний энэ саналыг хүлээж авсан байгаа.

2 дугаарт энэ дээр бид зөвхөн Байнгын хороо төдийгүй энэ Үндэсний зөвлөл дээр Сангийн яамнаас гадна Монголбанкны төлөөллийг заавал оролцох ёстой гэж бид үзэж байгаа. Энийг ч шаардаж байсан. Яагаад гэвэл Монголбанк тухайн бүрэн эрхт төлөөлөгчийг томилж байгаа. Эргээд бид бүрэн энэ асуудал бол бидний хяналтад байдаггүй. Хэдийгээр чиг үүрэг нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмээр уг нь эрх, үүрэг нь орчихсон ч гэсэн. Тэгэхээр энэ дээр бид зайлшгүй энэ асуудал дээр яагаад энэ өр авлагын асуудал бол эдгээр асуудал бол ялангуяа банкнуудтай холбоотой асуудал Монголбанкны шууд хариуцлагын асуудал. Тэр дампуурчихсан болон төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгж байгууллага нь мэдээж хэрэг тухайн аж ахуйн нэгж

байгууллагууд нь ямар шинж чанартай байна, банк бус бол Санхүүгийн зохицуулах хороо, эсвэл зүгээр аж ахуйн нэгж байгууллага бол бусад байгууллагуудаасаа энэ шууд хамааралтай асуудал гэж үзэж байгаа бидний хувьд.

Ер нь эргээд ялангуяа энэ нэгэнт жишээлбэл аж ахуйн нэгж байгууллагын ажил олгогчдын хувьд бид ялангуяа малчдад хэрвээ ингэж ийм хөнгөлөлттэй байдлаар бодлого явуулж байгаа энэ бол ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагуудын хувьд ч гэсэн ялгамжтай бодлого явуулах ёстой гэж бид үзэж байгаа. Ялангуяа жижиг, дунд бизнес эрхлэгч, гарааны бизнес эрхлэгч залуучууд, эмэгтэй бизнес эрхлэгч дээр бол нийгмийн даатгалын шимтгэлийн энэ дарамт хамгийн ихээр байдаг. Тийм учраас бид ялангуяа үндэсний зөвлөлийн гишүүд бид тэр сурталчилгааны ажлыг илүү тэр сайн дураараа нийгмийн даатгалын шимтгэл төлөгч малчдад илүү явуулах гэсэн ийм байр суурьтай байгаа. Тийм учраас энэ олон жилийн асуудлыг бид эргээд энэ өмнөх үндэсний зөвлөлийн гишүүд, өмнөх манай НДЕГ-ын удирдлага, тэгээд өмнөх, өмнөх сайдуудтай шууд энэ хариуцлагын асуудалтай холбоотой гэж бид үзэж байгаа. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Аудитын тайлан дээр ийм 4 дээр нь ийм зөрчил бичсэн байна. 4 сангийн санхүүгийн тайлан, нийт Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын харьяа 33 байгууллага байдаг юм байна. Энэ дээр ингээд аудит хийхэд 17 алдаатай зөрчлийг илрүүлсэн байна. 4 сангийн санхүүгийн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгөөд, 1 сангийн санхүүгийн тайланд бүүр дүгнэлт өгөхөөс татгалзсан байна. Энэ ямар байгууллага бүүр ингээд дүгнэлт өгөхөөс татгалзсан, нөгөө 4 сангийн байгууллага нь ямар байгууллага байгаа вэ? Энийг аудитаас тодруулж асуугаадахъя. 8 дугаар микрофон.

А.Цогбаяр: Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитын менежер Цогбаяр. Энхнасан даргын асуултад хариулъя. Тэгэхээр нийгмийн даатгалын сангийн тайлангаар нийтдээ 33 тайлан нэгтгэгдсэн байгаа. Үүнээс 13 тайланд нь түүврийн аргаар аудит хийсэн, 15 санхүүгийн тайлан зөрчилгүй, 4 санхүүгийн тайланд хязгаарлалттай, 1 санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан ийм дүгнэлттэй гарсан. Хязгаарлалттай дүгнэлт авсан аймгуудын хувьд Архангай, Өмнөговь, Сэлэнгэ, Архангай, Өмнөговь, Сэлэнгэ, Баянхонгор гэсэн 4 аймаг дээр хязгаартай санал, дүгнэлт өгсөн. Дүгнэлт өгөхөөс татгалзсан нь Говьсүмбэр аймгийн нийгмийн даатгалын хэлтэс дээр дүгнэлт өгөхөөс татгалзсан ийм дүгнэлт өгсөн байгаа. Дүгнэлт өгөхөөс татгалзсан байгууллага дээр бид Төрийн аудитын тухай хуулийн дагуу хариуцлага тооцох албан шаардлагыг НДЕГ-т хүргүүлсэн байгаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Ингээд чуулган хүлээгээд байгаа учраас шуурхай нэлээн явж байна. Гишүүд харин тийм, гишүүд асуултаа асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Зулпхар гишүүнээр тасаллаа. Эрдэнэбат гишүүн үгээ хэлнэ.

С.Эрдэнэбат: Нийгмийн даатгалын юун дээр олон жил энэний төлөө явсан учраас ингээд дахин, дахин яриад хэлээд байгаа та бүгд маань зөвөөр ойлгоорой. Үндэсний зөвлөл маань байгуулагдаад хараат бус хороо, мэргэжлийн хороод гээд харьцангуй нэг хэсэг нэлээн задгай байсан юмыг л цэгцлэх гэж үзэж байгаа. Энэ тал дээр нь би талархаж байгаа. Манай мэргэжилтнүүд, энэ хуулийг гаргахад ч гэсэн бид маш сайн том алхсан шүү дээ. Тэгээд энийгээ хамгаалахгүй хамгийн гол нь дуугай суугаад, балбуулаад л, цохиулаад л ерөөсөө нийгмийн даатгалын сан тэр чигээрээ болохоо байчихсан юм шиг ингээд суугаад, манай Үндэсний зөвлөл ч таг

суугаад байх юм, яам маань ч гэсэн ингээд таг суугаад байхад нь жоохон сэтгэл өвдөөд байгаа учраас миний хувьд хэлээд байгаа юм шүү. Тийм учраас та бүгд маань энэ тал дээр нэг жоохон идэвхтэй ажиллаарай. Тэгэхгүй бол нийгмийн даатгалын санг чинь юу ч болгож байгаад, тэгээд бараг бүгдээрээ өгөхгүй байя, төлөхгүй байя гээд ийм хэт юм руу явбал энэ санг бол эргээд босгоход тун хүнд. Хүний итгэлийг алдана гэдэг бол даатгал чинь өөрөө итгэл алдсан тохиолдолд эргээд сэргэхэд тун хэцүү байдаг. Тийм учраас өнөөдөртөө байгаа хамгийн институт байгууллагуудын төлөөлөл мэргэжлийн, нөгөө талаараа хараат бус ажиллах чадахуйц тийм хүмүүс хүмүүс байгаа учраас та бүгдийг хараат бус гэдэг юман дээр нь 2, 3 зүйл дээр нэлээн идэвхтэй ажиллаасай гэж бодож байна.

1 дүгээрт энэ тайланг Их Хуралд Байнгын хороонд тавиад байх биш олон нийтдээ тавь. Олон нийтдээ тавь. Нөгөө даатгуулагч нартайгаа, ажил олгогч нартайгаа тавь, бүүр уулзалт тэдний эргэлзээг нь гаргах тоон мэдээллийг өгөхгүй бол хүмүүс юуг л хүсэж байна гэвэл буулгаж л байвал хамаа байхгүй гэж үзээд байгаа юм. Тийм учраас энэ тал дээр нь яах вэ буулгах, буулгахгүйн завсар байгаа ирээдүйн эрсдэлүүд, параметруудийн өөрчлөлтүүд олон зүйлийг харахгүй бол зарим манай Их Хурлын гишүүд зөвхөн өнөөдрийнхөө хэдэн тоо, юун дээр анализ хийж байгаад болчих юм шиг харагдаад байгаа юм. Энэ чинь нөгөө параметрийн хооронд гулсах зүйл байж байна. Хуулийн цоорхой гарахаар ямар хурдан хуулийн цоорхойг ашиглаж хүмүүс энэнээс зайлсхийх вэ гэдэг том эрсдэлүүд байгаа. Энийг мэргэжлийн түвшинд та бүгд маань ингээд маш ойлгомжтой, тодорхой 177 хуудас биш, маш ойлгомжтой ийм байдлаар нэг талаар энэ нийгмийн даатгалынхаа санг сурталчлах энэ тал дээр илүү их ажиллаарай. Их Хурлын гишүүддээ нэг талаар жилдээ нэг тайлан тавих үеэр нэг уулзах биш, хууль орохоор нэг уулзах биш, үндэсний зөвлөлийн гишүүд бол Их Хурлын төлөөллийн байгууллага учраас бид нартаа мэргэжлийн зөвлөгөө дэмжлэг өгмөөр байна.

Энэ удахгүй чуулган дээр төсөв хэлэлцэх гэж байна. 14, 5 мянган хүн ажлаас халах гэж байна. Ажилгүйдлийн даатгалд ямар ачаалал өгөх юм, эргүүлээд даатгалын санд ямар нөгөө ажилгүй болсон хүмүүс чинь даатгалын сан тэр чигээрээ унана тийм үү, эрүүл мэнд унана. Тэгээд энэ тал дээр нь мэргэжлийн сөрөг үнэлэлт дүгнэлтүүдийг өгөхгүй бол магадгүй Сангийн яам ч гэдэг юм уу, өөр яамд ерөөсөө л үр ашигтай гэдэг байдлаас бүх зүйлийг хараад, бид бол нийгмийн хамгааллын салбар учраас энэ тал дээр нь сөрөг, эерэг аль, аль дүгнэлтийг нь өгөөрэй гэдгийг хэлмээр байна.

Тэгээд хурлаа ил тод хийж үзээрэй дээ. Би нэг журам гаргаад өгсөн хэдэн ч Байнгын хороо, гишүүн ч болохоос өмнө олон удаа өгч байсан. Хааяа зарим нэгэн хурлыг ил тод тавьж байя. Аль банканд хадгалах вэ, ямар хүүгээр хадгалах вэ, ямар эрсдэлүүд гарч ирэх юм энэ тэр гэдэг зүйлийг олон нийтэд мэдээлж болох энэ бол нээлттэй, ил тод хуралдчихад гэмгүй. Одоо бидний хурал ил тод л явж байгаа шүү дээ. Тэгэхгүй бол ингээд л тэгсхийгээд л ингээд хуучин арга барилаар, ингэсхийгээд л нэг юм оруулж ирээд л, тэгээд ингэсэн байдлаар явбал улам л холдоод байна. Тэр утгаараа тэр журмыг нь ч гэсэн өөрчилсөн.

Өр төлбөрийн асуудал байна. Хаа байсан хэдэн жилийн өмнөх, 10, 20 жилийн өмнөх хүртэл яваад байна. Энийгээ цэвэрлэх юм байдаг юм бол цэвэрлээд, засах юм байдаг юм бол засаад нэг балансаа цэвэрлэж авахгүй бол энэ чинь хаа байсан Хоточ банк ингээд л юу яваад л байх юм. Энэ тал дээрээ нэг аудитынхан тодорхой дүгнэлт хийгээд нэг тал руу нь болгоосой гэж бодож байна. Мэргэжлийн ийм дүгнэлт саналуудыг та бүгд минь өгөөрэй. Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдтэй

илүү их ойрхон, тэр болгон гишүүд минь олон асуудал хэлэлцдэг учраас зарим асуудал дээр тоон мэдээллүүд ил байж байдаг баймаар байна. Тэгэхгүй бол нэг бичиг явуулах юм, бичгийн дагуу л нэг заримд хагас дутуу мэдээлэл ирдэг. Энийг чинь үндэслэж байж маш олон зүйлүүд дээр шийдвэр гаргах гээд байгаа байхгүй юу. Нөгөө 10 саяас дээш цалинтай хүмүүсийн шимтгэлийг байхгүй болгоё гээд л ороод ирчихсэн байж байгаа. Нөгөө хөлсөөр ажиллах гэрээнүүдийг бүгдийг нь байхгүй болгоё энэ тэр гээд. Энэ чинь өөрөө асар том цоорхой үүснэ, энийг юугаар нөхөх вэ гэдэг талд нь мэдээлэл өгөөрэй гэдгийг хэлмээр байна. Амжилт хүсье гишүүдэд.

Л.Энхнасан: Баярлалаа. Зулпхар гишүүн үгээ хэлнэ үү.

С.Зулпхар: Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, гишүүд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийн энэ оройн амгаланг айлтгая. Энэ тайлан Байнгын хороонд танилцуулж байгаа нэг чухал сая ч гэсэн гишүүд хэлж байна. Бид зөвхөн тайлан танилцаад зогсохгүй цаашдаа ажил хэргийн уулзалтууд хийж байх ёстой юм байна гэж. Бид энэ Үндэсний зөвлөлийг мэргэжлийн тодорхой түвшинд ойлголттой, энэ талаар жишээ нь өөрийн гэсэн төсөөллөөс гадна туршлагатай улсуудыг зөвлөлийн гишүүн болгочихсон гэж ойлгодог шүү дээ. Тийм учраас та бүхний хариулт ч гэсэн тийм түвшинд байх ёстой. Та бүхэн бол зарим нь тайлангаа уншаагүй, бүрэн ойлгоогүй явж байгаа юм шиг ийм л сэтгэгдэл төрүүлчихлээ шүү дээ. Мэдээж уг нь та бүхэн мэдэж байгаа.

Энэ дээр жишээ нь сая гишүүд зарим нь нөгөө чуулгантай учраас гараад явчихлаа. Энэ нэг зүйлийг бид ингээд сүүлийн үед ингээд нийгмийн даатгалын сангийн тухай ярихаар зэрэг нийгмийн даатгалын сан ерөөсөө болохоо байчихсан юм шиг ийм сэтгэгдлийг л ерөөсөө улс орон даяараа төрүүлдэг боллоо. Гишүүд нь ч тэгж ярина. Та бүхний өгч байгаа хариулт ч тийм. Нийгэм нь тийм ойлголттой учраас хэвлэл мэдээллийнхэнтэй нийлж байгаад ерөөсөө энэ санг ер нь бараг байхгүй байх нь зөв гэж ойлгодог ийм юм руу л орлоо шүү, орлоо. Та бүхэн энэ дээр хариуцлага хүлээх ёстой болчихож байна гэсэн үг.

Одоо үйлчилгээ авч байгаа 700 гаруй мянган хүн байгаа. Цаашдаа яг одоо шимтгэлээ төлөөд явж байгаа 1,2 сая хүн байгаа шүү дээ. Одоогийн тоогоор нь бодвол 1,9 сая хүний өнөөдрийн болон маргаашийн эрсдэлийг дааж байгаа эрсдэлийн сан шүү дээ энэ чинь. Энэ эрсдэлийн сан өнгөрсөн 30 жилийн хугацаанд боломжоороо ажилласан. Боломжоороо ажилласан тэгээд тодорхой түвшинд манай нийгмийн эрсдэлийг даван туулах энэ том сорилтыг даван туулаад, зорилтоо биелүүлээд явж байгаа ийм сан шүү гэдгийг та бүхэн олон нийтэд сурталчилна. Дан ганц Их Хурлын гишүүд яриад ойлгохгүй, зарим Их Хурлын гишүүд нь улс төржөөд энийг чинь зүгээр ерөөсөө ний нуугүй хэлэхэд утгыг нь алдагдуулж байна шүү дээ. Тэгэхээр зэрэг энэ дээр та бүхэн оролцохгүй л бол яах юм бэ, энийг тэгвэл бид энэ зөвлөл байгаад яах юм бэ, зөвлөл шийдвэр гаргадаг байгаад яах юм бэ ийм байдал руу орж байна. Би бол хэд хэдэн удаагийн хурал дээр сууж байна.

Зүгээр бараг л жишээ нь нийгэмтэйгээ нийлээд л, улс төрчтэйгөө нийлж байгаад жишээ нь хариулт өгч байна шүү дээ. Сая Баяраа гуайн өгсөн хариулт бол дэндүү хариуцлагагүй хариултауд байна шүү дээ. Та зөвлөлийн хурал дээр яриад сууж байдаг байсан тэнд бол байр сууриа илэрхийлж болно. Энд та тайлангаа танилцуулаад, гарах гаргалгаагаа, шийдлээ яриад сууж байх ёстой байтал ийм хариуцлагагүй юм яриад сууж байна шүү дээ. Яах юм бэ энийг чинь олон нийт сонссон юм чинь үгүй ээ зөвлөлийн гишүүн ингэж хэлж байгаа юм чинь ийм л юм

байгаа юм байна гэж бодно шүү дээ. 30 жил болсон энэ хугацаанд бид гурвантаа том улс төрийн шийдвэр гаргасан. Гурвантаа гаргасан улс төрийн шийдвэрээс чинь болоод өнөөдөр санд өнгөрсөн хугацаанд 50 их наядын ийм ачаалал үүссэн. Энэ 50 их наядын ачааллаас болоод энэ сан дээр өөрт нь эрсдэлүүд үүссэн. Энийг та бүхэн сайн мэдэж байх ёстой. Мэргэжлийн улсууд энэ тоогоо мэдэж байх ёстой шүү дээ. Улс төрийн шийдвэр гаргасан. Гэхдээ цаашдаа гаргуулахгүйн төлөө бид тал талаас хичээж байгаа шүү дээ. Энэ дээр та бүхэн жишээ нь оролцох ёстой. Хамгийн ойрхон гаргасан шийдвэр чинь өнгөрсөн сонгуулийн өмнө гаргасан шийдвэр. Тэрийг өнөөдөр хэрэгжүүлж чадахгүй сууж байгаа шалтгаан нь ойлгомжтой шүү дээ. Сан чинь өөрөө эрсдэлтэй байгаа учраас энийг та бүхэн ярьдаг баймаар байна гэж байгаа юм.

Хууль батлагдсан 2023 оны 7 сарын 7-ны өдөр батлагдаад, 24 оны 1 сарын 1-нээс эхлээд хэрэгжсэн. Тэгэхээр та бүхэн нэг их энэ реформ хийгдээгүй юм шиг юм ярьж байна. Реформ хийгдсэн. Энэ чинь 10 гаруй жил хүлээгдэж байгаад энэ чинь 8 улсын бид өөрийнхөө жишээ нь өнгөрсөнтэй өнөөдрийг харьцуулж байгаад хийсэн судалгааны тооцооллын үндсэн дээр хийгдсэн хууль шүү дээ. Энэ хуулийг бид хэрэгжүүлээд явж байгаа шүү дээ. Энийг та бүхэн ярих ёстой шүү дээ. Тэгэхлээр энэ хууль хэрэгжсэнээс хойш бидэнд гарч байгаа үр дүнгүүдийг та бүхэн маш тодорхой ярих ёстой. Бид энийг ямар нэгэн байдлаар сурталчил гэж байгаа юм биш. Тэр мэргэжлийн хороод чинь, олон нийтийн мэргэжлийн хяналтын хяналтын зөвлөлүүд чинь энэний үр дүн дүнгээр гарч байгаа шийдвэрүүд чинь мөн шүү дээ. Тухайлбал та бүхэн 700 тэрбум төгрөгийн түрүүн тэр шийдвэр гаргаад, өнөөдөр энэ чинь дараа жил гэхэд 55 тэрбум төгрөг нэмэгдэхээр ингээд л шийдвэр гарчихсан л байгаа шүү дээ. Энэ чинь өөрөө цэвэр мэргэжлийн менежмент рүү орсны шинж мөн биз дээ. Энийг та бүхэн ярих ёстой.

Цаашлаад энэ дээр бид хагас хуваарилалтын зарчим руу шилжиж байгаатай холбоотой ямар сорилт байгаа юм, ямар боломж байгааг та бүхэн ярих ёстой шүү дээ, яриад олон нийтэд, бидэнд бас таниулах ёстой. Улсын Их Хурлын гишүүд чинь заримыг нь мэдэхгүй байгаа шүү дээ. Энийг та бүхэн ярихгүй.../минут дуусав/

Л.Энхнасан: 1 минут нэмье.

С.Зулпхар: Саяын 520 тэрбумын тэр авлагын асуудал яригдаж байна. Тэрийг та бүхэн мэдээд сууж байх ёстой шүү дээ. Энэ авлага чинь эдийн засаг хүндэрсэн үед дандаа бий болдог ийм нөхцөл байдал. Гэхдээ энэ авлагын араас жишээ нь байгууллага нь явж байдаг. Тэгээд энэ авлага хагас жилээрээ нэг барагддаг. Жишээ нь улирал тутмаар нэг барагддаг, оны төгсгөлд нэг барагддаг ийм л юм байгаа шүү дээ. Гэхдээ энэ дээр сая хэлж байна, уян хатан хуваарилалтууд, уян хатан зохицуулалтууд яаж хийж байна гэдгээ тайлбарлаж байгаа учраас энийг та бүхэн хамт яриад яваач л гэж байгаа юм.

Саяын хуулийн төсөлтэй холбоотой ярьж байна. Өмнөх хуулийн төсөл дээр биднээс огт санал авдаггүй байсан гэж. Та санал өгөх үүрэгтэй шүү дээ. Юу хийгээд, хаагуур явж байсан юм бэ? Одоо шинэ хууль дээр та нар бүүр оролцоод, энэнийг хуулийн төсөл болгоноор оролц. Би Адъяахүүг бол мэргэжлийн хүн сонгочихсон учраас сая сонсгол дээр та бол онцгой хариулсан шүү дээ. Яг түүн шигээ та энд оролцоорой гэж байгаа юм. Бусад гишүүд бас оролцоорой гэж байгаа юм. Хэдийгээр та бүхэн орон тооны бус ч гэсэн та бүхэн өөрсдөө хүсэж байж энэ зөвлөлийн гишүүн болсон шүү дээ. Хүсэж болсон зүйлдээ яг хүссэнээрээ бүрэн оролцоорой гэж байгаа юм. Тэгж байж энэ бид юмыг ярихгүй бол ингээд нэг ийм.../минут дуусав/

Л.Энхнасан: Тийм байна. Баярлалаа. Зулпхар сайд бас үнэхээр сайд байсан хүн учраас өнөөдөр ингээд үгээ хэлж байна аргагүй. Гишүүдийн хэлж байгаа саналуудыг сайн тусгаад, ер нь Үндэсний зөвлөл энэ Байнгын хороотойгоо нягт ажиллах хэрэгтэй байна. Жилд 1 удаа, Байнгын хороо бол журмыг нь баталчихсан, ил тод тайлангаа хурлаа хийдэг болж байгаа юм байна. Хурлын протокол бий болж байгаа юм байна. Өмнө нь байгаагүй гэж сонсоход сонин л байна. Гишүүдтэй ойрхон уулзаж, энэ мэдээллээр сайн хангах хэрэгтэй байна. Зарим юмыг нь ярьж, ярихгүй байх гэдэг дээр эргэлзэж болохгүй шүү дээ энэ чинь үнэн зөвийг нь хэлж байж л бид ойлгохгүй бол энэ олон нийгмийн даатгалтай холбоотой энэ реформууд чинь бид дахиад улс төрийн буруу шийдвэр гаргачихвал яах вэ, нийгмийн даатгалын сан байхгүй болбол яах юм. Энэ дээр бид анхаарч, мэргэжлийн та нар зөвлөгөөгөө өгч ингэж нягт хамтарч ажиллах хэрэгтэй байна. Байнгын хороо бүүр томроод, Хүний хөгжил, нийгмийн байнгын хороо болж байгаа. Тэгэхлээр гишүүдийн тоо бүүр их нэмэгдэнэ. Өнөөдөр хурлаа, тайлангаа хэлэлцэж дууслаа. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр хэлэлцэх үүрэгтэй. Энэ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу энэ жил ингээд хэлэлцлээ.

19.11 цаг

Тэгэхдээ ингээд нэг хэлэлцлээ гээд жилдээ 1 удаа уулзаад байж болохгүй. Цаашдаа байнга албан бус ч гэсэн уулзалдах шаардлагатай байна гэдгийг гишүүдэд анхааруулж хэлье. Өнөөдрийн Байнгын хорооны хурлыг дууссаныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА